

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

**КОРОНАВИРУС БА ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ХАРИУ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

/2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар/

(Мэдээлэл, лавлагаа)
СТ-20/401

Судлаачид: Г.Алтан-Оч (Ph.D)
Г.Билгээ
Д.Жигваагүнсэл
О.Нарантуяа
Р.Нургүл
Р.Оргилмаа
Э.Энхтүвшин
Д.Халиун

Улаанбаатар
2020 он

АГУУЛГА

1. АНУ.....	2
2. БНСУ.....	9
3. БНХАУ.....	19
4. ХБНГУ.....	23
5. Иран.....	27
6. Испани.....	29
7. Итали.....	32
8. ОХУ.....	39
9. Франц.....	46
10. Япон.....	51
Хавсралт.....	57

1. АНУ

Эх сурвалж:

- <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>
- https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html
- <https://www.usa.gov/coronavirus>
- <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>
- <https://www.whitehouse.gov/briefings-statements/remarks-president-trump-address-nation/>

	АНУ
Нөхцөл байдал	2020.03.23-ны байдлаар Covid-19 шинэ төрлийн коронавирусын халдварын 35070 тохиолдол бүртгэгдээд байгаагаас 458 хүн нас бараад байна. ¹ Халдвар нийслэл хот болон нийт 50 муж, Пуэрто Рико, Гуам, Виржин арлуудад бүртгэгдээд байна. ² (Засгийн гарын цахим хуудсан дээр хамгийн сүүлийн байдлаар 2020-03-20-ны байдлаар мэдээ байна.)
Холбооны Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<u>2020.01.31-нд</u> Ерөнхийлөгч Доналд Трамп “Шинэ төрлийн коронавирусний Covid-19 өвчин халдаах өндөр эрсдэл бүхий цагаач болон цагаач бус иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглох, энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ авах тухай” 9984 дугаартай зарлиг батлав. Тус зарлигт БНХАУ-аас АНУ руу аялан ирсэн гадаадын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглосон байна. <u>2020.02.28-нд</u> Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах төв нь онцын шаардлагагүй тохиолдолд Исламын Бүгд Найрамдах Иран Улс руу зорчихгүй байхыг ард иргэддээ сануулав. <u>2020.02.29-нд</u> <ul style="list-style-type: none"> • Ерөнхийлөгч Доналд Трамп “Шинэ төрлийн коронавирусний Covid-19 өвчин халдаах өндөр эрсдэл бүхий цагаач болон цагаач бус иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглох, энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ авах тухай” 9992 дугаартай зарлиг батлав. Тус зарлигт Исламын Бүгд Найрамдах Иран Улсаас АНУ руу аялан ирсэн гадаадын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг хориглосон байна.

¹ <https://www.worldometers.info/coronavirus/country/us/>

² https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html?CDC_AA_refVal=https%3A%2F%2Fwww.cdc.gov%2Fcoronavirus%2F2019-ncov%2Fcases-in-us.html

- Ерөнхийлөгчийн ажлын албанаас Итали болон БНСУ-аас ирж байгаа бүх аялагчдыг эрүүл мэндийн үзлэг шалгалтад зайлшгүй хамруулсны дараа хилээр нэвтрүүлэх үүрэг өгсөн байна. 2020.03.13-нд Ерөнхийлөгч Доналд Трамп Үндэсний хэмжээнд онц байдал зарлав.

Хууль тогтоомжийн чиглэлээр:

2020.03.06-нд “Коронавирустай тэмцэх, хариу арга хэмжээ авахад нэмэлт төсөв батлах тухай” (Coronavirus Preparedness and Response Supplemental Appropriations Act, 2020)³ хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар коронавирустэй дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад зориулж холбооны агентлагуудад **8.3 тэрбум ам.долларын яаралтай тусламж** олгохоор шийдвэрлэжээ.

Дээрх тусламжийн хөрөнгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулна. Үүнд:

- Вакцин болон шаардлагатай бусад эмнэлгийн хэрэгслүүдийг боловсруулах, үйлдвэрлэх болон худалдан авахад
- Улсын болон орон нутгийн эрүүл мэндийн агентлаг болон байгууллагуудад тусламж олгоход
- Өвчний тархалтын нөлөөнд өртсөн жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгоход
- АНУ-ын ЭСЯамд болон Төрийн департаментын барилга байгууламжуудаас нүүлгэн шилжүүлэлт хийх болон бусад яаралтай бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулахад
- Өвчин дэлгэрсэн бусад улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд зэрэг болно.

2020.03-18-нд

“Коронавирусын хариу арга хэмжээ-гэр бүлүүдийг тэргүүн ээлжинд хамгаалах тухай” (Families first coronavirus response act) хуулийг Конгрессоос баталсан байна. Тус хуулиар Covid-19 өвчний улмаас ажиллах боломжгүй болсон ажилчдад цалинтай чөлөө олгох, коронавирусыг үнэгүй оношлох, хүнсний тусламжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах ажилтнуудыг хамгаалах талаар нэмэлт арга хэмжээ авах зэрэг асуудлуудыг зохицуулахаар болсон байна.

2020.03-19-нд

Covid-19 өвчний эсрэг эдийн засгийн гурав дахь багц арга хэмжээний төслийг Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцэн баталсан бөгөөд Сенатын танхимаар хэлэлцэн хараахан шийдэлд хүрээгүй байна.

2020.03-20-нд

³ <https://www.congress.gov/bill/116th-congress/house-bill/6074>

Сангийн яамнаас Татвар төлөх өдрийг 2020-04-15-аас 2020-07-15 хүртэл хойшлуулсан байна. Энэ хугацаанд нийт татвар төлөгчдөд татвар төлөөгүй хугацаанд нэмэлт хүү тооцохгүй, торгууль ногдуулахгүй гэж мэдэгдсэн байна. Харин татварын буцаан олголтоо авч болох бөгөөд хүсэлт гаргасан иргэний асуудлыг яаралтай шийдвэрлэх болно гэж мэдэгдэв.

2020.03.11-нд

- Ерөнхийлөгч Доналд Трамп Covid-19 өвчний улмаас дэлхийн эдийн засаг болон Америк улсын эдийн засаг, иргэдийн амьдралд ихээхэн хохирол учирч байгаа тул **Европоос ирэх бүх аялал жуулчлал, ачаа тээврийг 2020.03.11-ний өдрөөс 30 хоногийн хугацаанд хориглосон** шийдвэр гаргаснаа мэдэгдэв. Тус хориг нь ИБУИНВУ-д хамаарахгүй байна. Түүнчлэн зохих эрүүл мэндийн үзлэгээр орсон АНУ-ын иргэд хилээр нэвтрэх эрхтэй байна.⁴
- 2020-03-16-нд **Европоос ирэх бүх аялал жуулчлал, ачаа тээврийг хориглосон шийдвэрт ИБУИНВУ-ийг хамруулахаар тогтсон байна.**
- 2020-03-21-нд **Канад улстай** хиллэх хилээ хаасан байна.

Ерөнхийлөгч болон түүний ажлын албанаас өвчний дэгдэлтийн улмаас хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхийг төлөвлөж буй бусад арга хэмжээнүүд⁵:

- Ерөнхийлөгч энэ өвчний дэгдэлтээс болж хохирсон бизнес эрхлэгчид болон ажилчдад эдийн засгийн хувьд тусалж дэмжихээ мэдэгдэв.
 - Жижиг бизнес эрхлэгчдийг удирдах газарт коронавирусний дэгдэлтийн улмаас хохирсон бизнес эрхлэгчдэд зээл олгож ажиллахыг үүрэг болгов. Энэхүү зээл нь коронавирусний улмаас үүссэн бэрхшээлийг даван туулахад нэмэр болно гэж үзэж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 50 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэхийг Конгресст уриалав.
- Ерөнхийлөгч банкируудтай уулзаж, өвчний дэгдэлтийн үеэр эдийн засагт нөлөөлөх хор нөлөө нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд түлхүү байгаа тул энэхүү санхүүгийн хямралыг даван туулахад зээлийн бодлогодоо өөрчлөлт оруулж, зээл олголт болон зээлийн эргэн төлөлтөнд уян хатан байдлаар хандаж хамтарч ажиллахыг хэлэлцэн зөвшилцөв.
- Ерөнхийлөгч эрүүл мэндийн даатгалын компанийн удирдлагуудтай уулзаж коронавирусний оношлуурын төлбөрийг эрүүл мэндийн даатгалд хамруулах болон телевизээр нэвтрүүлж буй

⁴ <https://www.whitehouse.gov/briefings-statements/remarks-president-trump-address-nation/>

⁵ <https://www.whitehouse.gov/briefings-statements/president-donald-j-trump-taken-unprecedented-steps-respond-coronavirus-protect-health-safety-americans/>

- өвчнөөс урьдчилан сэргийлэх эмчийн зөвлөгөөг нэвтрүүлэх зардлыг эрүүл мэндийн даатгалын компаниуд төлөх зэрэг шийдвэрт хүрсэн байна.
- Ерөнхийлөгч Сангийн яаманд хандан коронавирустий дэгдэлтийн улмаас хохирол амссан тодорхой иргэд болон бизнес эрхлэгчдээс авах татварыг хойшлуулах санал тавихаа мэдэгдэв.
 - Энэ арга хэмжээ нь эдийн засагт 200 тэрбум ам.долларын хөрвөх чадварыг бий болгоно гэсэн тооцоо хийгдсэн байна.
 - Ерөнхийлөгч цалингаас суутгах татварыг түр хугацаанд чөлөөлөх хууль батлахыг Конгресст уриалав.
 - Ерөнхийлөгч коронавирустий халдварын улмаас өвдсөн, хөл хорионд орсон, эсхүл өвдсөн хүн асарсан ажилчдад санхүүгийн тусламж үзүүлэх яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ мэдэгдэв.
 - Дээрх ажилчдад үзүүлэх санхүүгийн тусламжийн талаар арга хэмжээ авахыг Конгресст уриалав.
 - Ерөнхийлөгч коронавирустай тэмцэхэд бүхий л нөөц бололцоогоо дайчлан хамтран ажиллахыг засгийн газар болон хувийн хэвшлийнхэнд уриалав.
 - Ерөнхийлөгч өөрийн ажлын албанд эрүүл мэндийн ажилтнуудын амны хаалтны хангалтыг нэмэгдүүлэхийг үүрэг болгов.
 - Ерөнхийлөгчийн ажлын албанаас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын аюулгүй байдлыг ханган, тэдэнд өвчин халдварлахаас сэргийлэх үүднээс олон тоогоор амны хаалтыг үйлдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ авахаа мэдэгдэв.
 - Ерөнхийлөгчийн ажлын албанаас үр дүнтэй эмчилгээ, вакцин гаргаж авах үйл ажиллагаанд дорвитой алхмуудыг авч хэрэгжүүлсээр байна.
 - Ерөнхийлөгчийн ажлын алба нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хооронд нь холбосноор өвчний оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлж, хамрах цар хүрээ нь өргөжсөөр байна.
 - Орон даяар 1 сая оношлуур тараасан бөгөөд долоо хоногийн эцсээр буюу 2020-03-14-ний байдлаар 4 сая оношлуур нэмж тараахаар ажиллаж байна.
 - Орон даяар бүх мужуудын лабораториудыг оношлуураар хангасан ба хувийн лабораториуд мөн оношлуур хүлээн авснаар оношлох үйл ажиллагаа өргөн хүрээг хамарч байна.
 - Ерөнхийлөгчийн ажлын албанаас коронавирустий оношилгоо болон эмчилгээг эрүүл мэндийн даатгалд багтааснаар нэмэлт төлбөргүйгээр хийгдэх боломжтой гэж мэдэгдэв.

Хуулийн төслүүд өргөн барив.

- Коронавирусний дэгдэлттэй холбоотой нийгэм, эдийн засагт гарч буй хүндрэлүүдийг шийдвэрлэх, даван туулах зорилгоор Конгрессын гишүүд 10 хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн барьсан байна.⁶ Үүнд:
 - Covid-19 өвчний оношилгоог эрүүл мэндийн даатгалд хамруулах
 - Covid-19 өвчинтэй тэмцэж буй эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах
 - Шинэ коронавирүсний дэгдэлтийн үлмаас ажиллах боломжгүй болсон иргэдэд ажилгүйдлийн тэтгэмж олгох
 - Тахал, вирусний аюул, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон бусад шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн санаачилгаар Засгийн газраас яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх
 - Covid-19 өвчний үлмаас дэлхийн түүхий эд, бараа материал нийлүүлэлтийн үйл ажиллагаанд доголдол гарсан тул үлэмж хохирол амссан тодорхой ажилчдын асуудлыг 1974 оны Худалдааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар зохицуулах
 - Covid-19 тархсантай холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүднээс Сургуулийн үдийн хоолны тухай хуульд шаардлагатай өөрчлөлт оруулах
 - Covid-19 тархсантай холбоотой Холбооны сонгуулийн үеэр эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг мужийн засгийн газруудад даалгах
 - Сургуулийн хөл хорионы үеэр эмзэг бүлгийн хүүхдүүдэд хүнсний тусламж үзүүлэх эрхийг Хөдөө аж ахуйн сайдад олгох
 - Covid-19 өвчний үлмаас ажилтнуудад цалинтай чөлөө олгох зэрэг болно.

Холбооны, мужийн засгийн газрууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь Covid-19 вирусны тархалтыг хязгаарлах, үр дүнтэй эмчилгээг бий болгохоор чармайн ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд

- Орон нутгийн захиргааны байгууллага нь өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өвчний талаарх мэдээллийг хүргэн ажиллаж байна.
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах төв нь дэлхий нийтээр тархсан вирусийг судлан шинжлэх, тухайн орон нутагтаа хэрхэн энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх (хөл хорио

⁶<https://www.congress.gov/search?q={%22source%22:%22legislation%22}&searchResultViewType=expanded&KWICView=false>

тогтоох, хүмүүс олноор цуглах арга хэмжээг цуцлах, ажилтнуудад зайнаас ажиллах боломжоор хангах гэх мэт), тусламж үйлчилгээ үзүүлэх зэргээр ажиллаж байна.

- Холбооны засгийн газрын агентлаг-Эрчим хүчний газар нь хүрээлэн буй орчноо хамгаалах, цөмийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан болон технологийн шинэ нээлтийг судлах, турших чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний лабораториудад Covid-19-ын судалгаа шинжилгээг явуулж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн газар нь ажил олгогчид болон ажилтнуудад ажлын байран дээр Covid-19-өөс хэрхэн урьдчилан сэргийлэх, ажлын байраа хэрхэн ариутгаж, халдваргүйжүүлэх талаар мэдээллийг хүргэж байна.
- Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг нь Covid-19-ийг устгах, халдваргүйжүүлэх болон усаа хэрхэн хамгаалах талаар мэдээллийг хүргэж байна.
- Хүнс болон эм зүйн газар нь эмийн үйлдвэрүүдтэй хамтран вакцин, эм, оношилгооны тест гаргах ажлыг гүйцэтгэж байна. Эмнэлгийн ажилтан, мэргэжилтнүүдэд оношилгооны тестийг хэрхэн ашиглах талаар мэдээллийг тогтмол хүргэж байна.
- Онцгой тохиолдолд бэлэн байдал хангах газраас шинэ эмчилгээг судалж, турших үйл ажиллагааг явуулж байна.
- Хөдөө аж ахуйн газар нь хүнсний аюулгүй байдал болон тэжээвэр амьтдыг хэрхэн сэргийлэх талаарх мэдээллийг хүргэж байна.
- Хэрэглэгчийн санхүүгийн эрхийг хамгаалах товчооноос өвчин дэлгэрсний улмаас санхүүгийн хүндрэл, бэрхшээлтэй тулгарвал (төлбөр тооцоо төлөх, орлогогүй болох гэх мэт) хэрхэн зээл, тусламжид хамрагдаж, хүндрэлээс гарч болох талаар зөвлөгөө өгч байна.⁷
- Жижиг бизнес эрхлэгчдийн газраас бизнес эрхлэгчдэд Covid-19-ийн улмаас санхүүгийн болон бусад хүндрэл бэрхшээлтэй тулгарахаас хэрхэн урьдчилан сэргийлэх болон нэгэнт өртсөн тохиолдолд хэрхэн хүндрэлээс гарах талаар заавар зөвлөмж өгөхөөс гадна **“Гамшгийн үе дэх эдийн засгийн зээл” буюу хүү багатай тусгайлсан зээлд** хамрагдаж болох талаар мэдээллийг түгээж байна.
- Холбооны нөөцийн газраас (Federal Reserve) Covid-19 өвчний дэгдэлтийн үеэр эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахын тулд банк санхүүгийн байгууллагуудтай хамтран зээлийн хүүг 0 хүртэл хувь бууруулахаар шийдвэрлэсэн байна.

⁷ <https://www.consumerfinance.gov/about-us/blog/protect-yourself-financially-from-impact-of-coronavirus/>

	<ul style="list-style-type: none">• 2020-03-16-ны байдлаар өвчний тархалт өндөр байгаа Миннесота, Аризона, Хавай, Хойд Каролин болон нийт 30 гаруй мужид мужийн хэмжээнд ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоогоод байна.• Сургуулиудад хөл хорио тогтоосонтой холбоотой үнэгүй үдийн хоолонд хамрагддаг сурагчдад гэрээр нь хүнсний тусламж өгч эхэлсэн байна.
Аялал жуулчлал болон тээврийн талаар	<ul style="list-style-type: none">• Холбооны агаарын тээврийн удирдлагаас үйлчлүүлэгчиддээ заавар зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.
Өвчний тархалтын үеэр гарч болох гэмт хэргээс сэргийлэх талаар	<ul style="list-style-type: none">• Кибер аюулгүй байдал болон Дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах агентлагаас Covid-19 өвчинтэй холбоотой гарч болзошгүй залилан, луйвраас сэргийлэх зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.• Холбооны худалдааны комисс нь Covid-19-ийн талаар хуурамч мэдээлэл явуулах болон хуурамч эм, эмчилгээ зарж борлуулж буй компаниудын эсрэг арга хэмжээ аван ажиллаж байна.
Олон улсын харилцааны хувьд	<ul style="list-style-type: none">• АНУ-ын Төрийн департамент (Department of State) нь Covid-19 өвчинтэй тэмцэх ажилд бусад улс орнуудын засгийн газартай хамтран ажиллаж, АНУ руу зорчих болон АНУ-аас бусад улс орон руу зорчих иргэдэд зөвлөмж хүргэн ажиллаж байна.• АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь Covid-19 өвчинтэй тэмцэхэд олон улсын байгууллагуудад санхүүжилт олгож байна.

2.БНСУ

Эх сурвалж:

- Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас <http://ncov.mohw.go.kr/>
- БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас, https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp
- Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас, <https://gia.gov.mn/>
- БНСУ-ын банк <http://www.bok.or.kr/eng/bbs/E0000634/view.do?nttId=10057026&menuNo=400069>

БНСУ	
Нөхцөл байдал	<p>Анх бүртгэгдсэн: 2020.01.21 2020.03.23, 11:00 (Солонгосын цагаар)⁸</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн 24 цагт шинээр илэрсэн тохиолдол –64 • Нийт тохиолдол – 8961 Нас барсан-111 Эдгэрсэн-3166
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<p>2020.02.23-ны өдөр БНСУ-ын Ерөнхийлөгч Онцгой байдлын эрсдэлийг хамгийн дээд түвшинд шилжүүлсэн. 2020.02.26-ны өдөр Үндэсний Ассамблей эрх баригч болон сөрөг хүчний гишүүдээс бүрдсэн Корона вирустай тэмцэх арга хэмжээ авах онцгой албаны байнгын хороог байгуулсан. 2020.03.17-ны өдөр Боловсролын яамнаас бүх шатны сургуулийн хичээл эхлэх хугацааг 4 дүгээр сарын 16 болгож хойшлуулав. 2020.03.22-ны өдөр:</p> <ul style="list-style-type: none"> • 4 дүгээр сарын 6-ны өдөр хөл хориог цуцлах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллахыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад үүрэг болгов. • Европоос ирж буй нислэгүүдэд хорио цээрийн дэглэмийг чангатгав. 3 сарын 22-ны 00 цагаас эхлэн Европоос ирж буй бүх хүмүүст коронавирусний шинжилгээ хийж, сөрөг гарсан тохиолдолд 14 хоног өөрийгөө тусгаарлах зөвлөмжийг өгч байна. Үүний дагуу одоогийн байдлаар Европоос ирсэн 6 нислэгээр 1442 хүн ирснээс 152 хүнийг түр тусгаарлаад байна. Европоос ирж байгаа хүмүүсийн 92 хувь нь Солонгос улсын иргэд байна. Харин бизнесийн зорилгоор ирж буй иргэдэд байнгын ажиглалт, хяналт тавихаар шийдвэрлэсэн байна.

⁸ <http://ncov.mohw.go.kr/> Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас

Хууль тогтоомжийн чиглэлээр:	<ul style="list-style-type: none">• 4 сарын 5 хүртэл Гамшгийн аюулгүй байдлын төв штабын хурлыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн. Солонгосын Үндэсний Ассамблей болон Ерөнхийлөгчийн зүгээс улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг зохицуулах зорилгоор дараах хууль тогтоомжийг батлан гаргаад байна. Үүнд:
	<p><u>2020.02.26</u>-д 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p>
	<p>1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт⁹</p>
	<ul style="list-style-type: none">• Халдварт өвчний дэгдэлтийн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар• 1-р зэргийн халдварт өвчний дэгдэлт нь эм, ариун цэврийн хэрэглэл ба бусад бүтээгдэхүүний үнэ мэдэгдэхүйц өсөх, нийлүүлэлтийн хомсдолд хүргэх тохиолдолд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд нь дээрх бүтээгдэхүүнийг тус улсаас тодорхой хугацаанд экспортлох, гаргахыг хориглож болно. Хоригийг зөрчсөн тохиолдолд таван жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих, эсвэл 50 сая вон хүртэл торгууль ногдуулж болно.• Сэжигтэй өвчтөн эрүүл мэндийн үзлэг, мөрдөн байцаалтад хамрагдаж халдвар авсан нь тогтоогдсон бол эмнэлэгт тусгаарлана. Энэхүү арга хэмжээг дагаж мөрдөөгүй бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл 10 сая воноор торгох ялаар шийтгэж болно.• Эмнэлгийн ажилтнууд өвчтөний гадаадад зорчсон аялалын мэдээллийг цагдаа болон бусад байгууллагатай хамтран шалгах эрхийг олгох, мэдээлэл шалгагчаар ажиллах ажилтны тоог өргөжүүлсэ 2.Хорио цээрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт¹⁰
	<p>- Хорио цээр тогтоосон халдварт өвчний бүсэд нэвтрэхийг хориглох</p> <p>- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын баталсан төлөвлөгөөний дагуу эмнэлгийн байгууллагын ажилтнуудыг байнга мэдээллээр хангах, сургах</p> <p>- Халдварт өвчний дэгдэлтээс шалтгаалж хорио цээрийн бүсийг тогтоох, цуцлах гэх мэт.</p>
	<p>3.Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт¹¹</p>
	<p>Сэтгэл зүйн эмчилгээний шинэ тасаг нээх, эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг бүхий л төрлийн байгууллагууд халдварт өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчлан зохицуулсан. Тухайлбал:</p> <p>- эмнэлгийн байгууллагын ажилтан, өвчтөн, асран хамгаалагч, ажилчдын халдварын хяналтын тогтолцоог бий болгох</p>

⁹ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp

¹⁰ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

¹¹ https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

- эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдад эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой халдварын гарал үүсэл, шалтгааныг хянах зорилгоор халдварын хяналтын тогтолцоог бий болгох
- өвчтөний онош хадгалах системийг бий болгох ингэснээр эмнэлэг хаалттай байсан ч өвчтөний онош бүртгэлийг шууд харах боломжтой болно.
- халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн хэн ч бай шинжилгээ өгөхөөс татгалзвал тухайн иргэнийг **3 сая вон хүртэлх торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэхээр заасан.**

4.Цагаачлалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (2020.03.05)¹²

Тус нэмэлт, өөрчлөлтөөр БНСУ оршин суух болон ажиллах зөвшөөрөлгүй гадаадын иргэний ажиллуулсан бол **30 сая вонын торгууль ногдуулах, эсвэл хорих ялаар шийтгэх**, мөн тус улсад ажиллаж буй ажилтан, түүний төлөөлөгч Хууль зүйн сайдын зөвшөөрөлгүйгээр ажлын байраа өөрчилсөн бол **10 сая воноор торгохоор** заасан. Энэхүү захиргааны шийтгэлийг хууль зүйн сайд чөлөөлөх буюу хүчингүй болгох эрхийг өгсөн.

Өдөр тутамд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ

Тус улсын Гадаад хэргийн сайд Кан Гён Хва “Халдварын эрт үеийн шинжилгээ, оношилгооны боломжийг нэмэгдүүлэх хүрээнд хамгийн хурдан, аюулгүй оношилгоо болох машин дотор шинжилгээ хийх явуулын **“Drive-thru”** аргыг нэвтрүүлж иргэд 10 минутад багтаан шинжилгээ өгөх боломжтой болов. Мөн Инчоны нисэх буудлаар зорчигчдыг 3 шатны шинжилгээнд хамруулах зэрэг арга хэмжээ авч байна” хэмээн мэдэгдэв.

- + Коронавирусний талаар албан ёсны мэдээллийг хот тус бүрт албан ёсны цахим хуудас¹³ ажиллуулж байна. Энэхүү цахим хуудаст тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн статистик мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж, асуулт асууж хариулт авах булан, эмнэлгийн хаяг, байршил болон амны хаалт зэрэг шаардлагатай зүйлсийг худалдах талаарх мэдээллийг оруулах боломжтой. Мөн албан ёсны мэдээллүүдийг оруулдаг.
- + 3 дугаар сарын 9-өөс эхлэн амны хаалт худалдан авах ажлын зохион байгуулалтад оруулав. Төрсөн оны төгсгөлийн оронгоор ангилан заасан өдөр эмийн сан, зарим дэлгүүрээс өөрийн биеийн байцаалттай ирж худалдаж авах боломжтой. 1 хүн 1-2 ширхгийг авах боломжтой бөгөөд нэг амны хаалтны үнэ 1500 вон. Харин өндөр настан, 10-аас доош насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн хүн нь авах боломжтой бөгөөд хуваарьт өдрөө авч чадаагүй амралтын өдрөөр авч болохоор зохицуулж байна.

¹² https://korea.assembly.go.kr:447/res/tra_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

¹³ https://www.sejong.go.kr/prog/vod/covid19/sub01_07/list.do?searchCategory=63664514 Сэжон хотын коронавирус19 албан ёсны мэдээллийн цахим хуудас

1,6 төгссөн бол	Даваа гараг
2,7 төгссөн бол	Мягмар гараг
3,8 төгссөн бол	Лхагва гараг
4,9 төгссөн бол	Пүрэв гараг
5,0 төгссөн бол	Баасан гараг

- Зөвлөгөө өгөх 24 цагийн лавлах утаснуудыг ажиллуулж байна. Шинж тэмдэг илэрч буй хүн зөвлөгөө утас өгөх утсанд мэдэгдэж мэдээлэл авсны дараа эмнэлгийн байгууллагад хандана.
- “Covid-19”-ийн Гамшгаас урьдчилсан сэргийлэх төв штаб Улсын сэтгэлзүйн эрүүл мэндийн төв, Үндэсний сэтгэцийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эмч нараас бүрдсэн Сэтгэлзүйн зөвлөгөөний нэгдсэн баг байгуулж халдварын бүсэд ажиллаж буй эмч, сувилагч нарт сэтгэлзүйн зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг хийж байна.
- БНСУ-ын Химийн хүрээлэнгийн эрдэмтэд (CRIST) SARS, MERS вирусний эсрэг биеэс шинэ төрлийн коронавирүсний үйлчлэлийг сулруулагч эсийг олсон бөгөөд энэ нь вакцин, эмчилгээний аргыг гаргаж авахад тус болно гэж үзэж байна. Коронавирүсний гадаргуу хэсэгт байрлах “спайк” үүргийн үйлчлэлийг сулруулж чадвал халдварыг саармагжуулж чадах эсрэг биетийг гаргаж авах боломжтой болох юм. Саармагжуулах эсрэг биет нь вирус хүний биед нэвтрэхэд үйлчлэлийг нь сулруулж, дархлаа бий болгох эс юм. Эрдэмтдийн өмнө илрүүлж байсан SARS, MERS вирусийг саармагжуулах 11 төрлийн биетийн гурваас нь “спайк” хэмээх уурагтай нийлэгжих боломжтой биетийг олсон гэж тэмдэглэв. Эрдэмтэд энэ биетийг вирус дээр туршихаар төлөвлөж байна.¹⁴
- Вирүсний тархалтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цэргийн 96 эмчийг нэмэлтээр орон нутгийн харьяа эмнэлгүүдэд ажиллуулж байгаа бөгөөд мэргэжлийн дотрын эмч нар аж.

Эдийн засгийн үр нөлөөг бүүруулах чиглэлээр: “COVID-19” вирусний тархалт эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн үзэж байгаа ч Солонгосын Төв банк бодлогын хүүгээ 1.25 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргав. Түүнчлэн хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Төв банкнаас олгох тусгай зээлийн хэмжээг 5 их наяд вон (4.1 тэрбум ам.доллар)-оос 30 их наяд вон болгон нэмэгдүүлэв. Төв банк эдийн засгийн өсөлтийг 2.3 хувь хэмээн таамаглаж байснаа 2.1 болгон бүүлгажээ.¹⁵

¹⁴ <https://gia.gov.mn/53/item/668> Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газрын 3 дугаар сарын 12-ны өдрийн мэдээлэл

¹⁵ <https://gia.gov.mn/53/item/651> МУ-ын ТЕГ-ын 2 дугаар сарын 28-ны өдрийн мэдээлэл

2020 оны 03 дугаар сарын 12-ний өдөр Үндэсний Ассамблейн Төсөв, дансны тусгай хороо коронавирустэй тэмцэх үндэсний хэмжээний тэмцлийг дэмжих нэмэлт төсөв 11.7 их наяд воноор нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна¹⁶. Тус төсвийг коронавирустэй тэмцэх ажилд зориулахаас гадна жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой гэж хууль санаачлагчид мэдэгдсэн байна.

Тус улсын Засгийн газраас Корона19 халдварын улмаас хохирол амсч буй иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжийг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.¹⁷

Доор дурдсан эдийн засгийн тусламжийн үйлчилгээг авахыг хүсэгч нь Зээлийн нөхөн сэргээх хороо, Солонгосын хөрөнгө оруулалтын менежментийн корпорац (Үндэсний аз жаргалын сан) болон бичил санхүүгийн санд өргөдөл гаргах боломжтой.

Төрөл	Нэр	Агуулга
ЗЭЭЛ	Жижиг бизнесийн эдийн засгийн аюулгүй байдлын хөрөнгө	жижиг бизнес эрхлэгчид 70 сая вонын зээлийг 2 жилийн хугацаатай олгож, 3 дахь жилдээ эгүүлэн төлөх нөхцөлтэйгөөр
	Шинээр үүсгэн байгуулж үйл ажиллагаа эхлэх хөрөнгө	1 хүний 20 сая хүртэлх воныг 5 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй зээл
	Захын худалдаачдад зориулсан зээл	жижиг худалдаачдад 1 хүний 10 хүртэлх сая вонын 2 жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй зээл
	Тусгай хөрөнгийн дэмжлэг	жижиг дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид 1 жилийн хугацаатай (3 жил хүртэл сунгах боломжтой) 500 сая хүртэлх вонын зээлийг жилийн 1%-ийн хүүтэй
ТАТВАР	Компанийн татвар, НӨАТ-ын мэдэгдэл болон татвар төлөх хугацааг сунгах	Дээд тал нь 9 сар хүртэл
	Хураамж, хугацаа хэтэрсэн хураамжийг хойшлуулах	Хураамж-дээд тал нь 9 сар хүртэл Хэтэрсэн хураамж-дээд тал нь 1 жил хүртэл

¹⁶ https://korea.assembly.go.kr:447/wha/pre_read.jsp БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуудас

¹⁷ Ц.Өнөрзаяа, БНСУ-ын Күүкмин их сургуулийн багшийн орчуулга

<p>(Коронавирусний халдвараас болж хохирол амсч буй орон нутгийн татвар төлөгч болон эрүүл мэнд, аялал жуулчлал, үзвэр, хоол, зочид бүүдлын салбарын татвар төлөгчид)</p>	<p>Татварын байцаалт хойшлуулах болон түр зогсоох Коронавирусний цэвэрлэгээ, ариутгалыг төр хариуцах</p>	
<p>ОРОН НУТГИЙН ТАТВАР (Халдвар авсан өвчтөн болон тусгаарлалтад орсон иргэн, вирусний халдвар авсан иргэн очсоноос үүдэлтэйгээр үйл ажиллагаагаа түр зогсоож хүнд байдалд байгаа ААН-д)</p>	<p>Хувийн эзэмшлийн татвар, орон нутгийн орлогын албан татвар, иргэний татвар зэргийн мэдэгдэл, төлөх хугацааг сунгах</p>	<p>6 хүртэл сар, нэмж 6 сар сунгах боломжтой.</p>
	<p>Хураамж болон хугацаа хэтэрсэн хураамжийг хойшлуулах</p>	<p>6 хүртэл сар, нэмж 6 сар сунгах боломжтой.</p>
	<p>Татварын байцаалтаас чөлөөлөх Орон нутгийн татварыг бууруулах</p>	
<p>ГААЛИЙН ТАТВАР (Хятадад байгаа үйлдвэр хаагдсанаас түүхий эдийн хангамж болон экспортын хямралд орсон ААН)</p>	<p>Төлөх хугацааг хойшлуулах, хуваан төлөх боломж олгох</p>	<p>Дээд тал нь 1 жил</p>
	<p>Өдөрт нь гаалийн буцаан олголт хийх, гаалийн татварын байцаалтыг хойшлуулах</p>	
	<p>Гамшгийн үед туслах төв ажиллуулах</p>	
<p>ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ (Сайн түрээслэгч хөтөлбөр)</p>	<p>Жижиг дунд үйлдвэр эрхлэгч болон жижиг бизнес эрхлэгч нарын оны эхний 6 сарын түрээсийн төлбөрийг бууруулсан түрээслэгчийн уг хассан түрээсийн төлбөрийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг ААН албан татвараас суутган чөлөөлнө.</p>	
	<p>Захын мұхлагуудын түрээсийн төлбөрийг 20% хүртэл бууруулсан тохиолдолд тухайн захад хуучин кабель, усны төхөөрөмж, ус шүршигч зэрэг галын аюулаас хамгаалах төхөөрөмжийн багцыг үнэгүй суурилүүлж өгнө.</p>	
	<p>Улсын өмчлөлд байдаг хөрөнгийн хувьд 4 сарын 1-ээс он дуустал одоо авч байгаагийн 1/3 хувиар бууруулна.</p>	
	<p>Улсын өмчит газруудын түрээсийн төлбөрийг 6 сарын турш 20-35 хүртэл хувиар бууруулна.</p>	

БУСАД¹⁸	Моргежийн зээл (Халдварт өвчний тусгай бүсэд амьдардаг оршин суугчид хамаарах бөгөөд хориг тогтоосон шийдвэр гарснаас хойших хугацаа хамаарна)	Хугацаа хэтэрсэн бол 3 сар түдгэлзүүлэх, нэмэлт хүүгээс 3 сарын хугацаанд чөлөөлнө.
	Зээлийн төлбөрийг зогсоох	Уламжлалт захын худалдаачдын зээлийн үндсэн төлбөрийг 6 сар зогсоосон.

2020.03.16-нд Банкны мөнгөний бодлогын зөвлөл суурь ханшийг 3 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 50 хувиар буюу 1.25%-иас 0.75% болгон бууруулав. Мөн зээлийн хүүг 0.50-0.75%-иас 0.25% хүртэл бууруулжээ¹⁹.

2020.03.18-нд

- Үндэсний Ассамблей коронавирусний тархалтаас үүдэлтэй сөрөг нөлөөнөөс эдийн засгаа хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх зорилгоор 11.7 их наяд вон буюу 9.4 тэрбум долларын төсвийг нэмж баталлаа.
- Сангийн яамны мэдээлснээр:
 - Халдварт өвчний хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор төсвийг 0.15 их наяд воноор
 - Жижиг бизнес эрхлэгчид болон хохирогчдыг дэмжих төсвийг 1.4 их наяд воноор
 - ард иргэдийн амьдралын тогтвортой байдлыг хангах үүднээс төсвийг 0.8 их наяд воноор
 - Тусгай гамшгийн бүсийн болсон Дэгу, Чэонго, Гёнсан, Бонгва зэрэг хотын төсвийг 1.0 их наяд воны санхүүжилтийг нэмэгдүүлэв.²⁰

Халдварт өвчний хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Маск үйлдвэрлэх, нийлүүлэх
- Эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх
- Эмчилгээний хөгжүүлэлтэд
- Эмнэлгийн ажилтнуудын нэмэлт дэмжлэг (коронавирусний улмаас орон нутагт ажилласан эмнэлгийн ажилтнуудын дэмжлэг)

¹⁸ http://ncov.mohw.go.kr/upload/viewer/skin/doc.html?fn=1583916829598_20200311175349.hwp&rs=/upload/viewer/result/202003/ Эдийн засгийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ-Солонгос хэлээр

¹⁹ <http://www.bok.or.kr/eng/bbs/E0000634/view.do?nttid=10057026&menuNo=400069> БНСУ-ын банк

²⁰ http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board_id# Солонгосын коронавирус мэдээллийн албан ёсны цахим хуудас

Жижиг бизнес эрхлэгчид болон хохирогчдыг дэмжих төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Жижиг бизнес эрхлэгчдийн хөрөнгийн нийлүүлэлтийг өргөжүүлэх
- Хохирол амсаж буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх (нисэх, тээвэр, хүргэлтийн үйлчилгээ эрхэлдэг бизнест)

Ард иргэдийн амьдралын тогтвортой байдлыг хангах зорилгоор нэмэгдүүлж буй төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Бага орлоготой өрхөд хэрэглээний купон олгох
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Бага орлоготой өрхүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах
- НӨАТ-ыг бууруулах
- Бага орлоготой ажилчдад халамж дэмжлэг үзүүлэх
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал дэмжлэг үзүүлэх (хувийн цэцэрлэгийн үйл ажиллагааны тодорхой хэсэгт тусламж үзүүлэх)
- Цахим хичээлийн хүрээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Тусгай гамшгийн бүсийн болсон Дэгу, Чэонго, Гёнсан, Бонгва зэрэг хотын төсвөөр дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- **Гамшгаас хамгаалах бэлэн байдалд**
- Хохирол амссан дэлгүүрүүдийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх
- Цахилгааны төлбөрийг бууруулах (6 сар хүртэл хугацаагаар 50 хувь бууруулах)
- Бага орлоготой өрхийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах 3 сарын хугацаанд 50 хувь бууруулах)
- Дэгу, Гёнонгбүк хотод зориулсан тусгай дэмжлэг (Халамж, жижиг бизнесийн бодлогын сан зэрэг халамжийн санд зориулсан)

Халдвар, чиглэлээр: хамгааллын Халдварт өвчний тархалтыг барих, хамгаалалт, хяналтыг сайжруулах чиглэлээр дараах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Нэгдүгээрт: “Хяналт шалгалтыг өргөжүүлэх, Хяналтын байдлыг сайжруулах” Бид өвчтөнийг эрх олох болно.

1. Хяналтын зорилтыг өргөжүүлэх

Уушгины хатгалгааны шалтгаан тодорхойгүй өвчтөнүүдийг эмчийн үзлэгээр эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай.

Баталгаажсан өвчтөнтэй холбоо тогтоосон хүмүүсийн дунд ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй байсан ч зайлшгүй шаардлагатай бол эмч, асран хамгаалагч, гэр бүл болон бусад байцаагчаар шинжилгээ хийлгэх, хорио цээрийг дэглэмээс гаргахын өмнө шинжилгээ хийлгэх.

2 Шуурхай үзлэг, оношилгоо

Түүврийн цуглуулга хийх боломжтой скрининг эмнэлэг өргөжиж байна.

Оношилгооны шинжилгээний байгууллагуудын тоо өргөжиж (3-р сард 100-аас дээш), өдөрт 10,000 гаруй тохиолдол оношлох боломжтой болсон.

3.Хяналтын хүртээмжийг сайжруулсан

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн удирдлагын төв аюулгүй, үр дүнтэй шинжилгээ, оношилгоо зохион байгуулах ажлын хүрээнд “Тээврийн хэрэгслийн явуулын үзлэгийн төв”-ийг байгуулаад байна. Түүнчлэн эмчилгээний төвүүдийг шинээр нээн ажиллуулж байгаа бөгөөд 03 дугаар сарын 04-ний өдөр шинээр 3 эмчилгээний төв нээжээ.

Хэрэв сэжигтэй өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эмнэлгийн байгууллагад очиж чадахгүй байгаа ахмад настнуудын хувьд орон нутгийн түүвэр цуглуулах баг (эмч, сувилагчдыг оролцуулан) очиж үзнэ.

Хоёрдугаарт: Эмнэлгийн байгууллагууд, асрамжийн газрууд гэх мэт эмзэг бүлгийн газруудад өвчтөний шилжилт хөдөлгөөнийг хориглох, амьсгалын замын өвчнөөс урьдчилан сэргийлэх замаар бид хамтын халдвараас урьдчилан сэргийлэх болно.

1.Өвчтөний эмнэлгийн байгууллагад орохыг хориглох

Хэрэв халуурах, амьсгалын замын шинж тэмдэг, сэжигтэй шинж тэмдэг илэрвэл (дүрслэл, цээжний таагүй байдал, ерөнхий сулрал гэх мэт) яаралтай тусламжийн өрөөнд орохын өмнө оношилгооны шинжилгээ хийдэг.

Яаралтай эмнэлгийн тусламж авах шаардлагатай хүнд өвчтөнүүд тусдаа хорио цээрийн бүсэд байх ёстой.

2.Эмнэлгийн байгууллагад амьсгалын замын өвчтэй хүмүүсийг тусгаарлах

Хэрэв эмчийн үзэмжээр аюулгүй байдлыг хангах боломжтой бол өвчтөн эмнэлгийн байгууллагад шууд очихгүйгээр утасны зөвлөгөө, жорыг авах боломжтой бөгөөд ингэснээр эмнэлгийн байгууллагад халдвар авахаас сэргийлнэ.

3.Хэрэв өвчтөн халуурах, ханиалгах зэрэг шинж тэмдэг илэрвэл өвчтөний үулзалтыг хориглоно. Бүх зочдыг халуурч, амны хаалт зүүж, гар ариутгах шинжилгээ хийлгэх ёстой.

4.Шилжилт хөдөлгөөнийг хаах

Халуурах, ханиалгах зэрэг шинж тэмдэг бүхий ажилчдыг ажлаас нь чөлөөлж, оношилгооны шинжилгээнд хамруулдаг. Шинж тэмдэг илрээгүй байсан ч Хятад, Хонконг, Макао зэрэг цагаачлалын тусгай журамд хамрагдсан газруудаар аялж байсан бол 14 хоногийн турш ажлаас чөлөөлөгдөнө²¹.

²¹ http://ncov.mohw.go.kr/duBoardList.do?brdId=2&brdGubun=21&dataGubun=&ncvContSeq=&contSeq=&board_id=#header Халдвар хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл, солонгос хэлээр

3.БНХАУ

Эх сурвалж:

- <http://en.nhc.gov.cn/>
- <http://www.consul.mn/>
- <http://www.xinhuanet.com>
- <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>
- <https://gia.gov.mn/12/item/652>
- http://en.nhc.gov.cn/2020-03/25/c_78235.htm

	БНХАУ
Нөхцөл байдал	<p>2020.03.24-ны байдлаар Хятадын Үндэсний эрүүл мэндийн хороо (ХҮЭМХ)-ноос гаднаас ирж буй иргэдээс 47 тохиолдол илэрч, 33 сэжигтэй тохиолдол илэрсэн бол 4 хүн нас барсан байна. Нийт бүртгэгдсэн тохиолдол 81218, нас барсан -3281 хүн, эдгэрч, эмнэлгээс гарсан – 73650 хүн байна.²²</p> <p>Сүүлийн үед БНХАУ-ын хэмжээнд COVID-19 халдварын тохиолдол гадаадаас ирж буй иргэдээс илэрч байгаатай холбогдуулан 3 дугаар сарын 23-ны өдрийн 00:00 цагаас эхлэн Бээжин хотод буух олон улсын нислэгийг нислэг үйлдэж буй агаарын тээврийн компаниас хамааран нэр бүхий 12 нисэх буудалд буулгаж, зорчигчдыг шалган нэвтрүүлэх болсон байна.²³</p> <p>Хүбэй мужийн шинэ коронавирүсийн уушгины тахлаас урьдчилсан сэргийлж, хянах төв 2020.03.24-ний өдөр мэдэгдэл гаргаж: 2020.03.25-ны 00:00 цагаас эхлэн Хүбэй мужийн Үхань хотоос бусад нутгуудын Хүбэйгээс гарах замын хөл хориог цуцалж, Хүбэйгээс гарах хүмүүс Хүбэй Эрүүл мэндийн код дээр суурилсан "Ногоон код" авсан нөхцөлд аюулгүй, дэг журамтай зорчиж болно. Үхань хотод мөн Хүбэй муж, Үхань хотоос гарахгүй хатуу хөл хорио тогтоох бодлогыг хэрэгжүүлж, 2020.04.08-ны 00:00 цагаас эхлэн Үхань хотод тавьсан хөл хориог цуцлан, Хүбэй мужийн эрүүл мэндийн кодоод суурилсан "Ногоон код" авсан нөхцөлд Хүбэй муж, Үхань хотоос гарч, аюулгүй эмх цэгцтэй зорчиж болно гэжээ.</p> <p>Энэхүү мэдэгдэлд тэмдэглэхдээ, 2020.03.25-ны 00:00 цагаас эхлэн Хүбэй мужийн Эрүүл мэндийн кодын "Ногоон код" эзэмшдэг хот орж хөдөлмөр үйлчилгээ хийх хүмүүс нуклейн хүчлийн шинжилгээ хийсний дараа "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлж, тусгай зориулалттай хүргэх" аргаар ажилд орох аюулгүй байдлыг нь</p>

22

23 <http://www.consul.mn/index.php?moduls=19&id=292>

баталгаажуулна гэжээ. Үхань хот тахлын эрсдэлд үнэлгээ хийсний дараа урьдчилан сэргийлж хянах ажлыг сайтар хийх нөхцөлд боломж бүрдсэн аж ахуйн нэгжүүдийн ажлыг сэргээхийг дэмжиж байна. Гэхдээ Хүбэй мужийн дотоодын их дээд сургууль, дунд бага сургууль, тусгай мэргэжлийн сургууль, хүүхдийн цэцэрлэг зэргийн үйл ажиллагааг үргэлжлэн түр хойшлуулахаар шийдвэрлэжээ.²⁴

Вакцин: БНХАУ-д шинэ коронавирусний зарим вакцины клиникийн туршилтыг ойрын хугацаанд эхлүүлэхийг төлөвтэй байна. Шанхайд бүтээж буй вакцины клиник туршилтыг 4 дүгээр сарын дундуур эхлүүлэхийг мэдэгдсэн. Судалгааны зарим баг клиник туршилтад хамрагдах сайн дурынхныг бүртгэж эхэлсэн.²⁵

Авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ

Халдварын голомттой бүсэд (Хүбэй мужийн Үхань болон бусад 15 хот, 50 сая хүн ам) карантин тогтоох, олон нийтийн тээвэр, үүнд автобус, галт тэрэг, нисэх онгоц, усан онгоц зэргийн хөдөлгөөнийг түр хаасан. Үхань хотын нисэх буудал, галт тэрэгний буудал, метро зэргийн үйл ажиллагааг түр зогсоож, хөл хорио тогтоосон. Үйлдвэр, сургууль, оффисуудын үйл ажиллагааг түр зогсоож, ажлаа гэрээсээ хийхийг уриалсан зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.²⁶

Хүбэй мужийн Чаньжян хот (*1 сая орчим оршин суугчтай*)-ын дарга вирусний халдвар авсан байж болзошгүй хүний талаар мэдээлэл өгч, шинжилгээгээр халдвар авсан нь тогтоогдсон нөхцөлд **10 мянган юань /1425 ам.доллар/-ийн** урамшуулал олгоно хэмээн мэдэгдсэн.

Хятадын Засгийн газар томоохон технологийн компаниуд болох Alibaba Group Holding Ltd, Tencent Holdings Ltd нартай хамтран Ханжоу болон бусад зарим хотод халдвартай холбоотойгоор иргэдийн хөдөлгөөнийг хянах, болзошгүй эрсдэлийг бууруулахад big data болон QR код зэрэг технологийг ашигласан системийг нэвтрүүлсэн бөгөөд үүнийг “one map, one QR code, and one index” гэж нэрлэж байна.

Хотын оршин суугчид болон хотод нэвтэрсэн хүн бүр аппликейшн дээрх асуумжийг бөглөх бөгөөд өөрсдийн бүртгэлийн дугаар, гадаад, дотоодод зорчсон тухай болон биеийн байдлынхаа талаарх мэдээллийг оруулсны дараа тухайн хүний эрүүл мэндийн байдлыг илтгэсэн өнгө бүхий QR кодыг авах юм.

²⁴ http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c_1125763807.htm

²⁵ http://www.xinhuanet.com/english/2020-03/17/c_138888228.htm

²⁶ <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>



【绿码】

凭码通行



【黄码】

实施7天内隔离，连续（不超过）7天健康打卡正常转为绿码



【红码】

实施14天隔离，连续14天健康打卡正常转为绿码

Улаан кодтой иргэн 14 хоног өөрийгөө тусгаарлаж, өөрийн биеийн байдлын талаар тогтмол мэдээлнэ.

Шар кодтой иргэн 7 хоног өөрийг тусгаарлаж, холбогдох мэдээлэл өгнө.

Ногоон кодтой иргэн чөлөөтэй зорчино. Тусгаарлалтын тогтоосон хугацаа дууссаны дараа ямарваа нэгэн шинж тэмдэг илрээгүй бол улаан, шар өнгө бүхий код ногоон болно. Иргэдийн эрүүл мэндийн байдлын мэдээлэлд Ханжоугийн Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих төв байнгын хяналт тавьж ажиллана.²⁷

- ✚ БНХАУ-ын Засгийн газар “бага эрсдэлтэй” газар орны Цагаачлалын албыг виз болон паспортын үйлчилгээг сэргээх, “дунд эрсдэлтэй” газарт нөхцөл байдалтайгаа уялдуулан үйлчилгээг сэргээж болох зөвлөмж өгсөн байна.
- ✚ Тус улсын Цинхуа болон Бээжингийн их сургуулиудын албан ёсны цахим хуудсанд 2020 оны 6 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хичээлийг байршуулж эхлээд байгаа бол жижиг сургуулиуд “WeChat” аппликейшныг ашиглан оюутнуудад хичээлүүдийг хүргэж байна.²⁸

Эдийн засгийн үр нөлөөг чиглэлээр БНХАУ-ын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулахаас гадна “Covid-19” вируст өртсөн бүс нутгуудын жижиг, дунд бизнес эрхлэгч болон иргэдийн зээлийн хүүг бууруулах, зээлээ эргэн төлөх хугацааг хойшлуулах зэрэг төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч үйлдвэрлэлийн сүлжээнд тасалдал үүссэн нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг бууруулах эрсдэлтэй байна.

2020.02.25-ны өдөр БНХАУ-ын Төрийн зөвлөлийн хуралдаанаар жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүг бууруулах, халдварын

²⁷ <https://www.weforum.org/agenda/2020/03/coronavirus-covid-19-hangzhou-zhejiang-government-response/>

²⁸ <https://gia.gov.mn/12/item/652>

улмаас зээлээ төлж чадаагүй иргэдийн зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах, торгууль ногдуулахгүй байх шийдвэр гаргаад байна. Тус хүралдаанаар жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэхээр 500 тэрбум юанийг төсөвлөв. Мөн хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн зээлийн хүүг 0.25 нэгжээр бууруулж 2.5% болгожээ.²⁹

Хятадын Төв банк өнгөрсөн долоо хоногт бодлогын хүүгээ бууруулж, банкууд болон зээлдэгчдэд ирэх зээлийн хүүгийн дарамтыг багасгахад туслах үүднээс зээлд их хэмжээний бэлэн мөнгө зах нийлүүлж эхлээд байна.

Мөн БНХАУ-ын Ардын банкны дэд дарга Лю Гуокян эдийн засгийн өсөлтийг дэмжих, үйлдвэрлэлийн алдагдлыг нөхөх үүднээс дотоодын нэр бүхий өсөн банканд нэг жилийн хугацаатай, бага хүүтэй зээлийг санхүүжүүлэх чиглэлд тусгай санхүүжилт гаргаж, бизнес эрхлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр богино хугацаанд зээл олгох чиглэл өгсөн байна. Хамгийн сүүлд тус улсын Сангийн яамнаас “Covid-19” вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулж улсын төсвөөс 8 тэрбум юань гаргах болсноо зарласан. Түүнчлэн Төв банк нь санхүүгийн байгууллагуудад олгосон 200 тэрбум юань буюу 28.65 тэрбум ам.долларыг нэг жилийн хугацаатай, зээлийн байгууламжийн хүүгээ 3.25-аас 3.15 хувь болгон бууруулах болсноо мэдэгдээд буй.

Хонконг

Бослого тэмцлийн улмаас эдийн засаг нь өнгөрсөн онд 1.2 хувиар агшсан бол одоо шинэ коронавирусний гамшиг Хонконгийн санхүүгийн нөхцөл байдлыг улам доройтуулахаар байгаа юм. Тиймээс Хонконгийн эрх баригчид хоёр сая орчим иргэнийхээ татварыг хөнгөлөх, бага орлоготой иргэдийн байрны нэг сарын түрээсийн төлбөрийг чөлөөлөх, амьжиргааны түвшин доогуур 200 мянган өрхөд нэг удаагийн тэтгэмж олгохоор болжээ.³⁰

²⁹ <https://gia.gov.mn/12/item/652>

³⁰ <https://livetv.mn/p/163369>

4.ХБНГУ

Эх сурвалж:

1. Холбооны Улсын Эрүүл мэндийн Яам <https://www.bundesgesundheitsministerium.de/coronavirus.html>
2. 2020 coronavirus pandemic in Germany https://en.wikipedia.org/wiki/2020_coronavirus_pandemic_in_Germany
3. COVID-19-Fälle in Deutschland https://de.wikipedia.org/wiki/COVID-19-F%C3%A4lle_in_Deutschland
4. Үндэсний пандемийн төлөвлөгөө-Шинэ төрлийн корона вирусний өвчлөлийн нэмэлт ["Ergänzung zum Nationalen Pandemieplan – COVID-19 – neuartige Coronaviruserkrankung"](#) (PDF). *www.rki.de. Robert Koch Institute. Retrieved 4 March 2020.*
5. “Америкчууд вирусийн тархалтын улмаас галт зэвсэг ихээр худалдаж авч буй тул АНУ-д буй Монголчууд сонор сэрэмжтэй байх нь зүйтэй” Монгол Улсын Тагнуулын Ерөнхий газар <http://www.sonin.mn/news/culture/109580>

	ХБНГУ
Нөхцөл байдал	<p>2020-03-11 Канцлер А.Меркель мэдэгдэл хийв:⁴ -Компаниудын төлбөрийн чадварыг дэмжих зорилгоор Германы хөгжлийн банк (KfW)–наас энэ 7 хоногтоо багтаан санхүүжилт олгоно -Хилийг хаахгүй</p> <p>2020-03-12 Эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын газраас “тахал” гэж албан ёсоор зарлаагүй байна.³</p>
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<p>2020-01-31 Халдвараас хамгаалах хуулийн 6 ба 7 дахь зүйлийг үндэслэн “бүртгүүлэх үүрэг”-ийг журамлав. Тус журмаар, мөн сэжигтэй тохиолдол батлагдаагүй ч бүртгүүлэх үүрэг хүлээнэ.³</p> <p>2020-02-27 Дотоод хэргийн болон Эрүүл мэндийн яамны хамтарсан хямралын штаб байгуулагдав.³</p> <p>2020-03-02 Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдэлийн үнэлгээний түвшинг ахиулж “тааруу” гэж зарласан.³</p> <p>2020-03-04 Үндэсний пандемийн төлөвлөгөөнд корона вирусын өвчлөлийн талаар нэмэлт оруулав.⁴</p> <p>2020-03-06-ны өдрөөс хойш Норд-райн-вэст-фалэн муж улсын Хайнсберг тойргийг “онцгой тархалттай бүс”-ээр зарласан.³</p> <p>2020-03-11 ДЭМБ “цар дэгдэлт” (пандеми) зарлав.³</p> <p>2020-03-11 Бундестаг коронавирусын талаар Засгийн газрын сонсгол хийв.¹</p> <p>2020-03-12 Хэдийгээр хил залгаа улс орнууд дунд сургуулийг хаасан байгаа ч Германы Боловсролын сайд сургуулийг хаах тухай асуудал огт яригдахгүй гэж мэдэгдлээ.</p> <p>2020-03-13 Германы 16 улсын 14 нь дунд сургууль, цэцэрлэгийг хэдэн долоо хоногийн турш хаахаар шийдвэрлэв.</p>

2020-03-14

- Нэлээд хэдэн улсад олон нийтийн үйл ажиллагаа явуулахыг хориглов. Тухайлбал, Берлин, Шлесвиг-Холштайн, Заарланд улсуудад түүнээс гадна мөн баар, цэнгээнт газруудыг хаав.
- Көлнд хотын төвд цуглахыг хориглов.

2020-03-15

- Баварид хямралын дундуур орон нутгийн сонгууль явагдлаа. Сонгуулийн штабын олон ажилтан ажлын байраа орхисноос сонгууль үр дүнгүй болох эрсдэл нүүрлэв.
- Германы Дотоод хэргийн сайдын шийдвэрээр Франц, Швейцар, Австри, Дани болон Люксембургтэй хилээ хаав. Арга хэмжээ Даваа гаригаас эхэлж хэрэгжих ба бараа тээвэр болон орон нутгийн нислэг хамаарахгүй аж.
- Германы төмөр зам бүс нутгийн тээврээ хязгаарлаж, тийз шалгалтыг зогсоов.

2020-03-16

- Бавари Улсад 14 хоногийн **онц байдал зарлаж**, олон нийтийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, эмнэлгийн тусламж, хангамжид зориулан нэмэлт хөрөнгө гаргахаар шийдвэрлэв.
- Бүх спортын болон цэнгээнт газруудыг хаав. Хооллох зориулалтаар ресторанууд 15:00 хүртэл ажиллана, гэхдээ зөвхөн 30 хүртэлх үйлчлэгч авна. Их дэлгүүр, химийн бодис зардаг дэлгүүр, банк, хөнгөн зуушны газар болон үндсэн хэрэгцээ хангадаг бүх төрлийн аж ахуйн нэгжүүд уртасгасан цагаар, бүр Ням гарагийн өдөр ажиллаж болно. Харин чухал биш (барааны) дэлгүүрүүдийг бүгдийг хаана.³
- ХБНГУ-ын Тээврийн яам Иран, Хятадаас ирэх бүх нислэгийг зогсоолоо.³
- Үдэш нь Меркель Холбооны Улсын хэмжээнд Баваритай ижил арга хэмжээ авч байгааг мэдэгдэв, хот хоорондын тээвэр, шашны хурал цуглаанд нэгдэх, талбайд тоглох болон аялал жуулчлалыг хориглов.³

2020-03-17

- Роберт Кох Институт (RKI) Олон нийтийн эрүүл мэндийн Эрсдлийн үнэлгээний түвшинг ахиулж “өндөр” гэж зарлав.³
- Үдэш нь Меркель, ЕХ-ны бусад удирдагчидтай зөвшилцөн ЕХ-ны бус иргэнийг 30 хоногийн хугацаанд ЕХ руу нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэснийг мэдэгдэв.
- Европын комисс хамтарч анагаах механизм олох ажлыг эхлүүлэв.

2020-03-18

- Гёттинген Их сургуулийн эрдэмтэд корона вирусийн хүний эсэд бэхжин үлдэх чадварыг нойр бүлчирхайн үрэвсэл, зарим төрлийн хорт хавдрын эмчилгээнд хэрэглэдэг Япон Улсад үйлдвэрлэсэн “Мезилат Камостата” гэх эмээр устгах боломжтойг тогтоосон байна.⁵
- Роберт Кох Институт, хэрэв нийгмийн харилцааг (хавьтлыг) эрс бууруулахгүй, шууд харилцааг 1.5 метрээс доошгүй зайнд барихгүй бол өвчлөгчдийн тоо 10 сая хүрнэ хэмээн анхааруулав.
- ЕХ-ны Итали, Швейцар, Дани, Люксембург болон Испани улсын иргэдийг агаарын болон усан замаар Герман руу нэвтрэхийг хориглов. Хоёр талын хэлэлцээрийн дагуу Хятад, Иранаас агаарын тээврээр зорчигч хүлээж авч байсныгаа хоёр өдрийн өмнөөс эхлэн бүр мөсөн хориглов. Эдгээр зорчигчдоос вирусын шалгалт авалгүй, биеийн халууныг нь хэмжилгүй нэвтрүүлж байсан аж.
- Засгийн газраас ЕХ-ны бус оронд аялж явсан хэдэн мянган иргэнээ тусгай үүргийн онгоцоор татан авах ажиллагаа зохион байгуулав.
- Олон нийтийн эрүүл мэндийн даатгалын компаниуд хямралтай холбогдох бүх зардлыг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр нөхөн олгохоо мэдэгдэв.

2020-03-19 Германы нэгэн амны хаалт үйлдвэрлэгч бүх үйлдвэрлэсэн хаалтыг борлуулж дууссанаа мэдэгдэв. Зарим эмнэлэг хамгаалах хувцас дутагдаж буйгаа зарлав.

2020-03-20

- Бавари Улс анхлан 4 хоногийн өмнө Австри Улсад хэрэгжүүлсний нэгэн адил **хөл хорионы цаг тогтоов**. Хөл хорио 24 цагт эхэлнэ, зөрчигчид 25 мянга хүртэл еврогийн торгууль оногдуулна. Гэхдээ ажилд явах болон их дэлгүүр, ундааны дэлгүүр, эмийн сан руу ганцаар буюу гэр бүлийн нэг гишүүний хамтаар явахыг зөвшөөрсөн хэвээр аж. Мөн дээрх нөхцөлтэйгээр задгай талбайд спортоор хичээллэх, хамтран амьдрагчийндаа, эсвэл өндөр настныд зочлох, өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах, ерөнхийдөө бүх төрлийн тусламж үзүүлэх болон амьтан арчилж болно. Драйв-Ин болон Тэйк-Эвайгаас бусад бүх ресторан (хоолны газар), үсчиний газрыг хаав.
- Заарланд Улс мөн 24:00 цагаас эхлэн хөл хорио тогтоов. Гэхдээ зарим хөнгөлөлттэй. Улс хооронд, ялангуяа Францтай хил залгаа нутгаар униформ буюу халааттай зорчихоор журамлав.

2020-03-21

- Засгийн газар Холбооны Улсын засгийн газарт муж Улсуудын ЗГ-тай харьцуулахад илүү эрх мэдэл олгох хуулийн төсөл боловсруулав. Шинэ хуулийн дагуу Эрүүл мэндийн сайд нь Муж улсуудын хил нэвтрэхийг хориглох, халдвар авсан хүний харилцсан замналыг тогтоох, мөн эмч, эмнэлзүйн оюутан болон эмнэлгийн ажилтнуудыг халдварт өвчинтэй тэмцэх ажилд дайчлах эрхтэй болно.
-

	<p>2020-03-22</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газар болон холбооны үлсүүд 2-оос дээш хүн цугларах, олон нийтийн газарт хүнээс 1.5 метрийн зай барих (гэр бүл, хамтран амьдрагч болон нэг гэрт амьдардаг хүмүүст хамаарахгүй) асуудлаар зөвшилцөлд хүрэв. - Ресторан болон үсчин зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний газруудыг хаав.
<p>Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ</p>	<p>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь томуугийн вирусээс хамгаалах аргатай яг адилхан:¹</p> <ul style="list-style-type: none"> • Гарыг тогтмол, сайн угаах • Зөв ханиах, нийх • Өвчтөнөөс зай барих • Гар барихгүй байх <p>Арга хэмжээний хэрэгжих хэлбэрүүд</p> <ul style="list-style-type: none"> • Аяллаас зайлсхийх¹ • Нийтийн тээврээс татгалзах • Гэрээсээ ажиллах • 1000-аас дээш хүн оролцсон арга хэмжээнд оролцохгүй байх • 60-аас дээш настай ахмадууд пневмококийн эм тариулах • Гадаад аяллаас ирсэн бол: <ul style="list-style-type: none"> ○ Шаардлагагүй хүнтэй уулзахгүй байх; гэртээ байх. 14 хоногийн дотор шинж тэмдэг илэрвэл утсаар урьдчилан ярьж, эмчид хандах ○ Иран, Итали, Япон, БНСУ-аас ирсэн бол 30 хоногийн хугацаанд байх хаягийг өгөх ○ Хятадаас ирсэн бол нэмээд дэлгэрэнгүй хувийн мэдээлэл өгөх
<p>Эдийн засгийн нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ</p>	<p>2020.03.13</p> <ul style="list-style-type: none"> • ЕХ руу Германаас гарах экспортыг хөнгөвчлөхөө мэдэгдэв. Засгийн газар хямралд өртөөд байгаа урлаг, уран сайхан, соёлын байгууллагууд болон том арга хэмжээ зохион байгуулагч компаниудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болов. • Хувийн бүх компаниудад хүссэн хэмжээгээр нь хязгааргүй зээл олгохоо амлав. • Герман 10 000 ш агааржуулагч сэнс захиалж авахаар шийдэв (энэ Италийнхаас 2 дахин их хэмжээ аж), энэ нь тухайн үйлдвэрийнх нь бүтэн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ юм.

5. ИРАН

Иран	
Нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> • Иран Улс нь коронавирусний халдварын улмаас нас барсан хүний тоогоор БНХАУ-ын дараа 2-р байранд, халдвар авсан хүний тоогоор БНХАУ, БНСУ зэрэг улсуудын дараа орж дэлхийд 4-р байранд орж байна. Эрүүл мэндийн яамны 2020.03.23ны өдрийн мэдээллээр 18000 хүн халдвар авч, 1284 хүн нас барсан байна. Өнгөрсөн 24 цагийн хугацаанд 149 хүн нас барсан ба энэ нь 10 минут тутамд нэг хүн “Covid-19”-ийн улмаас нас барж байна гэсэн үг юм. • Парламентын 23 гишүүн коронавирусын халдвар авсан тул Парламентын үйл ажиллагааг одоогоор зогсоосон байна. • Коронавирусний тархах гол цөм нь Ираны сүм хийд болоод байна. Хэдий халдвар авагчдын тоо олон болоод Эрүүл мэндийн яамнаас сүм хийдүүдийг хаах зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг биелүүлэхгүй байгаа. • Ираны Эрүүл мэндийн сайд Киануш Жаханпур коронавирусийн эсрэг тэмцэлд АНУ-ын зүгээс тус улсад авсан эдийн засгийн хатуу хориг арга хэмжээнүүд саад болж байгааг онцолжээ.
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн яамнаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж гаргасан • Улс хоорондох агаарын тээврийг бүрэн зогсоосон • Агаарын харилцаагаа тасалсан улсуудаасаа өөрийн улсын иргэдээ авчрах болсон • Сүм хийдийг хаах зөвлөмж гаргасан • Бүх сургуулийг сарын хугацаатай хааж, зайны сургалтад шилжсэн • Кум хотод эмнэлэг хүрэлцээгүй болсноор майханд ор бэлтгэн, сэжигтэй тохиолдлуудыг хүлээн авч эхэлсэн • Ираны Ардын армийн 300.000 цэргийг корона вирусаас урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулахаар болсон • ОХУ-аас коронавирусийн дэгдэлттэй тэмцэхэд тусламж үзүүлэхийг хүссэн • Шинэ корона вирусийн халдвар шоронд тархаж болзошгүй гэж болгоомжлон эрх баригчид нийт 70,000 хоригдлыг сулласан тухай Хууль зүйн сайд Эбрахим 2020.03.22-нд мэдээлсэн

**Урьдчилан сэргийлэх
арга хэмжээ**

- Гарын ариун цэвэр сахих
- Амны хаалт хэрэглэх
- Дархлааг дэмжих эм хангамжийг сайжруулах
- Такси болон орчны цэвэрлэгээ ариутгал хийх
- Уулзалт, цугларалтыг хязгаарлах

**Эдийн засгийн нөхцөл
байдал**

Иран Улсын хувьд газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн асуудал буурч байгаа явдал эдийн засгийн хувьд хүнд байдалд орж байна. Энэ тал дээр дорвитой арга хэмжээ авч чадахгүй байгаа бөгөөд тархалтыг намжаах байдал дээр анхаарч байна.

6.ИСПАНИ

Улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ³¹:

- Итали Испани чиглэлийн шууд нислэгийг түр зогсоосон.
- Парламентын үйл ажиллагааг 1 долоо хоногийн хугацаанд түр хаасан.

Үндэсний эрүүл мэндийн системийн Дотоод бүс нутгийн зөвлөлөөс (Inter-territorial Council of the National Health System) коронавирусний халдвартай бүс нутагт авсан арга хэмжээнүүд³²

	Испани
Нөхцөл байдал	2020.03.23-ны 17 цагийн байдлаар ³³ Нийт бүртгэгдсэн -29909 Шинээр бүртгэгдсэн - +1141 Нийт нас барсан - 1813
Улс орон даяар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд³⁴	<ul style="list-style-type: none"> - 2020.03.11-наас Улс орон даяар 15 хоногийн хугацаатай онц байдал зарласан. - Парламентын үйл ажиллагааг 2020.03.25-ны өдөр хүртэл (15 хоног) түр зогсоосон. - 2020.03.19-нд Канарын арлууд руу нисэх нислэгийг түр хязгаарласан. Балеарийн арлуудын бүх нислэгийг түр хориглосон. - 2020.03.22-нд Ерөнхий сайд улс орон даяар 15 хоногийн хугацаатай зарласан онц байдлыг 2020.04.11 хүртэл сунгах хүсэлтийг Парламентад өргөн мэдүүлэхээ мэдэгдсэн. Ийнхүү сунгахыг Парламентаар батлах ёстой бөгөөд Парламентын ээлжит хуралдаан хуваарийн дагуу Лхагва гарагт хуралдахаар байна. - 2020.03.22-нд Мурсия мужийн Тэргүүн зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх эдийн засгийн үйл ажиллагааг түр хаах шийдвэр гаргав. - 2020.03.22 Испаний Зэвсэгт хүчин нь хэт ачаалалтай эмнэлгээс өвчтөнүүдийг ачаалал бага бусад эмнэлэг рүү шилжүүлэх, эрүүл мэндийн тоног төхөөрөмж зөөвөрлөх, гадаадад байгаа испаничуудыг нутаг буцаах арга хэмжээнд оролцон ажиллахаар болсныг Ерөнхий сайд мэдэгдлээ³⁵.

³¹<https://www.worldometers.info/coronavirus/>

³²<https://www.lamoncloa.gob.es/lang/en/gobierno/news/Paginas/2020/20200310covid19-measures.aspx>

³³<https://www.worldometers.info/coronavirus/>

³⁴https://en.wikipedia.org/wiki/2020_coronavirus_pandemic_in_Spain

³⁵<https://www.thestar.com.my/news/world/2020/03/22/spain039s-pm-to-see-coronavirus-state-of-emergency-extension-for-15-more-days---reports>

- 2020.03.22 Засгийн газраас гадаадын иргэдийг агаарын зам болон далайн боомтоор нэвтрэхийг 30 хоногийн хугацаанд түр хязгаарлав. Европын Холбооны улсуудын удирдагчид ийнхүү хилээ түр хаах арга хэмжээг ижил хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцов³⁶.
- Дрон ашиглан иргэдийнхээ хөдөлгөөнийг хянах болсон³⁷.

Сургууль болон бусад боловсролын байгууллагад хамааралтай арга хэмжээ

- Бүх боловсролын байгууллагын танхимаар хичээллэх үйл ажиллагааг түр зогсоох
- Боловсролын бусад нэмэлт үйл ажиллагааг түр зогсоох
- 2020.03.18-нд Баскийн Боловсролын сайд цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр хаасан шийдвэрийг тодорхойгүй хугацаагаар сунгав.

Байгууллага, ажлын байранд хамааралтай арга хэмжээ

- Боломжтой бол зайнаас гэрээсээ ажиллах (үтсаар гэх мэт)
- Онцгой байдлын үед хөдөлмөрийн үйл ажиллагааны тасралтгүй төлөвлөгөөг хянах, шинэчлэх.
- Уян хатан ажлын цагийг хэрэгжүүлэх, нэг ээлжинд ажиллаж байгаа ажилчдын тоог багасгах видео хурал хийхийг уриалга гаргасан

Эрсдэлт бүлгийнхэнд хамааралтай арга хэмжээ

- Ахмад настнуудад зориулсан гэрийн асаргааг дэмжих
- Архаг өвчнөөр шаналж буй, плурипатологи, төрөлхийн дархлаа дарангуйлагдсан өвчтэй настай хүмүүс орон гэр, оршин суугаа газраасаа аль болох гарахгүй байх. Хүмүүстэй харьцахдаа аль болох хол зайнаас, дор хаяж 1 м зайнаас харьцах

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Хувь хүний үүрэг хариуцлагаа ухамсартай мөрдөх, онцын шаардлагагүй бол аялахгүй байх.
- Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрвэл шууд эмнэлэг явах биш эхлээд гэртээ байж хэсэг хугацаанд ажиглах

Эдийн засгаа хамгаалах арга хэмжээ

- Испаний Ерөнхий сайд коронавирусын улмаас эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад 200 тэрбум еврогийн тусламжийн багцыг зарлав. Үүнд:
- Моргейжийн төлбөрийг хойшлуулах,
 - нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөвчлөх,

³⁶ <https://www.thestar.com.my/news/world/2020/03/22/spain039s-pm-to-see-coronavirus-state-of-emergency-extension-for-15-more-days---reports>

³⁷ <https://www.telesurenglish.net/news/Spain-Takes-Sweeping-Measures-as-COVID-19-Escalates-20200318-0027.html>

- хамаатан садангаа асрах шаардлагатай ажилчдад ажлаас чөлөө олгох зэрэг арга хэмжээг хамруулсан байна.

200 тэрбум еврогийн тал хувь нь бизнес эрхлэгчдэд, 17 тэрбум еврог COVID 19 өвчний нөлөөнд хамгийн их өртөж болзошгүй эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэхэд зарцуулахаар болжээ. Түүнчлэн, ажилгүйдлээс сэргийлэх, COVID 19-ийн вакциныг гаргахад дэмжлэг болох юм³⁸.

Урьдчилан сэргийлэх зорилгоор

- Гараа савандаж угаах, дор хаяж 20 секунд угаах. Саван, ус байхгүй бол спирт бүхий гар ариутгагч бодис хэрэглэх.
 - Угаагаагүй гараараа нүд, хамар, амандаа хүрэхээс зайлсхийх
 - Өвчтэй хүмүүстэй ойр дотно харьцахаас зайлсхийх.
 - Ханиалгах, эсхүл найтаах үед ам, хамраа салфетка, алчуур эсхүл, ханцуйгаараа (гар биш) дарах.
-

³⁸ <https://english.elpais.com/society/2020-03-17/spain-announces-200-billion-relief-package-against-effects-of-coronavirus.html>

7.ИТАЛИ

Эх сурвалж:

- Италийн Засгийн газар -<http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>
- Италийн эрүүл мэндийн яам-<http://www.salute.gov.it/nuovocoronavirus>

	Итали
Нөхцөл байдал	<p>2020.03.23, 16:00 цагийн байдлаар: Нийт тохиолдол – 59138 Нийт нас барсан тохиолдол 5476 Нийт эдгэрсэн- 7024</p>
Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд³⁹	<p>Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) нь 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдөр Хятад дахь коронавирусын дэгдэлт тархалтыг олон улсад нөлөөлж болзошгүй нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал гэж зарласан. Үүнээс нэг өдрийн хойно Италийн засгийн газар нь 1-р сарын 22-наас эхлэн авч хэрэгжүүлж байсан <i>анхны урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ өөрчилж</i>, халдварын тархалтын өргөн цар хүрээт шинж чанарыг харгалзан онц байдал зарлаж, улсыг бүх газар нутгийн хэмжээнд халдварыг тогтоон, зогсоох анхны арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн. Итали улсад Covid-19 өвчний анхны тохиолдлууд бүртгэгдсэн 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлээд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • 2020.01.30. Эрүүл мэндийн яамны тушаалаар: <ul style="list-style-type: none"> - ЭМЯ-нд ажлын хэсэг байгуулж, ОУ-ын холбогдох байгууллагуудтай байнгын харилцаатай байж урьдчилсан сэргийлэх ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд Хятадын талаас нислэгийг түр зогсоосон хэдий ч Хятад руу явах болон Хятадаас ирэх бүх нислэг, мөн Ухань хот руу болон Уханиас ирэх нислэгийг Итали улсын зүгээс нөхцөл байдлыг хянах, урьдчилан сэргийлэх ажлуудыг Олон улсын өндөр түвшинд авч хэрэгжүүлэхээр болжээ. • 2020.01.31. Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар: <ul style="list-style-type: none"> - ДЭМБ-аас тунхагласан “Олон улсын нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл”-ийг дагалдан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх онцгой нөхцөл байдлыг хууль ёсоор 6

³⁹ <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299>.

- сарын хугацаанд тогтоож, нийгмийн хамгааллын энэхүү шаардлагыг хангахад шаардагдах төсвийн санг баталсан.
- Итали Хятадын хоорон дахь нислэгийг түр зогсоосон.
 - **2020.02.01. Үйл ажиллагааны хорооны хуралдаанаар:**
 - Вирусын тархалтын тухайн үеийн нөхцөл байдалтай үялдсан үйл ажиллагааг дүгнэн түр хугацаагаар агаарын болон усан замын хөдөлгөөнтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулж бэлтгэх тухай хэлэлцэв.
 - Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд “Тусгай үйл ажиллагааны нэгж” байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргав.
 - **2020.02.04-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Нийгмийн хамгааллын газартай хамтран бүх нисэх буудал, боомтын эрүүл мэндийн хяналт үзлэгийг эрс сайжруулах шийдвэр гаргав. Энэ хүрээнд Ром хотод гаднаас ирж буй бүх хөдөлгөөнд эрүүл мэндийн хяналтын коридор, халуун хэмжигч скайнер ажиллуулж эхэлсэн.
 - **2020.02.07-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Итали Хятадын хоорондох нислэгийг түр зогсоосон шийдвэрийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэв.
 - **2020.02.21-ний Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар:**
 - Эрүүл мэндийн яамнаас №85/Covid-19 “Шинэ албан ёсны хөл хорионы арга хэмжээ ба идэвхтэй хяналт” зөвлөмж бүхий захирамжийг хэвлэн нийтлэв. Үүнд: шинжилгээний хариу эерэг гарсан хүмүүсийн ойрын хавьталд орогчид албан ёсоор хөл хорионд орох, ойрын 14 хоногт эрсдэлтэй бүсэд байсан хүмүүс гэртээ тусгаарлах, орон нутгийн захиргаанд үнэн зөв мэдээлэх үүрэгтэй талаар зөвлөсөн.
 - **2020.02.23-ны Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаан, Засгийн газрын хуралдаанаар:**
 - СнЗ-ийн ерөнхийлөгч, ерөнхий сайд Конте-ийн санаачилгаар Covid-19 өвчний тархалтыг зогсоон, удирдах шуурхай арга хэмжээ бүхий зарлиг батлав. Энд Ломбарди, Венето зэрэг халдварын өндөр тархалттай бүс нутгуудыг “Улаан бүс” хэмээн зарлав.
 - **2020.02.24-ний Засгийн газрын хуралдаанаар:**
-

- Эдийн засаг ба санхүүгийн сайд Роберто Гуалтиери Улаан бүс хэмээгдэх хотуудад оршин суугч татвар төлөгчдийн үүргийн тухайд интервенц хийх шийдвэр гаргав.
 - **2020.02.25-ны СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлиг:**
 - 2020.02.23-ны шуурхай арга хэмжээний зарлигт нэмэлт оруулав. Үүнд бүх төрлийн спортын үйл ажиллагаа, сургуулилт, сургууль болон дээд боловсролын үйл ажиллагаа, хорих ангиуд дахь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, жолооны шалгалтыг хэрхэн өгөх зохицуулалт, соёл ба аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар зохицуулсан.
 - **2020.02.28-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Covid-19 амьдралын нөхцөл байдалтай холбоотой гэр бүл, ажилтнууд ба бизнесийг шуурхай дэмжих арга хэмжээний талаар зарлигийг батлав.
 - **2020.03.01-ний СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Ерөнхий сайд Конте Covid-19-ын халдварын тархалтыг зогсоох, хянах талаар өмнө 2020.02.23-ны өдөр баталсан зарлигийг дахин шинэчлэн, интервенцийн ажлыг нэгдсэн байдлаар хийх зохицуулалтыг бий болгох үүднээс бүх нутаг дэвсгэрт урьчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зарлиг гаргав.
 - **2020.03.04-ний Засгийн газар, нийгмийн хамгааллын байгууллагууд, орон нутгийн захиргаадын хамтарсан хурлын шийдвэрээр:**
 - Ерөнхий сайд Конте, Боловсролын сайд Люсиа Аззолина нар Итали даяар боловсролын бүх үйл ажиллагааг 3.5-3.15-ныг хүртэл халдвараас сэргийлэх үүднээс түр зогсоох шийдвэрийг зарласан.
 - **2020.03.06-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Covid-19 –ийн тархалттай тэмцэх шуурхай бөгөөд онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шүүхийн үйл ажиллагаан дахь сөрөг үр дагаврыг арилгах, үндэсний эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах тухай зарлигийг батлав.
 - **2020.03.08-ны СнЗ-ийн хуралдаанаар:**
 - Ерөнхий сайд 2020 оны 3-р сарын 1-4-ний өдрийн тогтоолууд үр дүнгүй байгаа учраас дахин тогтоол гаргаж Ломбарди мужийн бүс болон бусад 14 мужийн нутаг дэвсгэр дэх (таван Эмилия-Ромагнагаас, таван нь Пьемонт, гурав нь Венецо, нэг нь Марчегээс) 16 сая хүнийг хамруулан хэсэгчлэн хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргав.
-

- Ерөнхий сайдын 2020 оны 3-р сарын 8-ны өдрийн зарлигтай холбогдуулан Дотоод хэргийн сайд Лусиана Ламоргезе "бэхэлсэн бүсэд хяналт тавих ажлыг гүйцэтгэх удирдамжийг батлав. Энэ хүрээнд онцын чухал шалтгаант ажил, эрүүл мэндийн асуудал зэргээс бусад тохиолдолд тус бүсээс гарах болон нэвтрэхийг хориглов.
- Мөн бүх төрлийн иргэний ёслолын үйл ажиллагааг түр зогсоосон. Үүнд: оршуулгын зан үйл ч багтсан.
- Бар цэнгээний газрууд үйлчлүүлэгч тус бүрийн хооронд 1 метрийн зайтай байх нөхцөлийг ханган оройн 18.00 цаг хүртэл ажиллаж болно.
- Чийрэгжүүлэх газрууд, музей, усан сан, театрууд, бооцоот тоглоомын газруудыг хааж, спорт зааланд олноороо бэлтгэл хийхийг хориглосон.
- **2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар:**
 - **03 дугаар сарын 11-нээс** эхлэн Италийн **бүх нутаг дэвсгэрт хорио, цээрийн дэглэм тогтоож** урьд өмнө авсан арга хэмжээгээ улам бүр чангатгасан.⁴⁰
 - хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасан.
 - Эрүүл мэндийн систем, иргэд, бизнесийн үйл ажиллагаанд өгч байгаа дэмжлэгийг улам бүр бэхжүүлж, иргэний хамгаалалт болон аюулгүй байдлын нөөц боломжийг нэмэгдүүлэх үүднээс 2020 онд цаашид өрийг хэрхэн зохицуулах талаар Парламентад тавьсан тайланг (3 дугаар сарын 5-нд баталсан) хэлэлцэж, Сайд нарын Зөвлөлийн №36 зарлигийг батлав. Танхимын захиргаанаас санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.
- **2020.03.14-ний өдөр.** Ерөнхий сайд 2020.03.11-ний СнЗ-ийн хуралдаанаар хүнс болон үндсэн хэрэгцээний барааны худалдаа, эм үйлдвэрлэл болон эмийн сангаас бусад бүх арилжаа болон жижиглэнгийн худалдааны газруудыг хаах шийдвэр гаргасантай холбогдуулан Ерөнхий сайд Конте Италийн үйлдвэрчний эвлэл болон нийгмийн түншлэлийн байгууллагуудтай видео уулзалт хурал хийж ажилтнуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, зайнаас ажиллах нөхцөл бололцоогоор

⁴⁰ <http://www.governo.it/it/approfondimento/coronavirus/13968>- Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

хангах, зайлшгүй тохиолдолд 1 метрээс ойргүй зайг барьж ажиллах, ажилтнуудын цалин хөлс, амралт, бусад нэмэгдлийг доголдолгүй олгох, үйл ажиллагааны онцгой горимд шилжих, урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны санамжийг байнга түгээх, ажлын байранд томоор хүмүүст харагдах газарт байрлуулах зэрэг авах арга хэмжээний тухай протоколд гарын үсэг зурлаа.

- **2020.03.16-ны Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар:**
 - Covid 19 цар тахлын онц байдал зарласантай холбогдуулан Улсын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлж, гэр бүл, ажилтан, бизнест эдийн засгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай тогтоол баталлаа. Уг тогтоолд:
 - ✓ Улсын эрүүл мэндийн систем, иргэний хамгаалалт ба онцгой байдлын ажилд оролцох бусад төрийн байгууллагуудыг санхүүжүүлэх ба бэхжүүлэх бусад арга хэмжээ;
 - ✓ Ажлын байр ба орлогыг хамгаалах үүднээс ажил эрхлэлт ба ажилчдыг дэмжих;
 - ✓ Банкны системээр ба төв даатгалын санг ашиглан гэр бүлийн, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй, бизнес эрхлэгчдийг кредит дэмжлэг үзүүлэх;
 - ✓ Татвар болон хувь хандив, бусад татварын үүргүүдтэй холбоотой төлбөрийн үүргийг түр зогсоох, ажлын байрны ариутгалд татварын урамшуулал олгох, ажил үйлчилгээгээ эрхэлж байгаа ажилтнуудад бонус шагналт олгох зэрэг үндсэн 4 чиглэл ба бусад салбаруудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд интервенц хийхээр болжээ.
- **2020.03.19-нд Сайд нарын зөвлөлөөс** Иргэний хамгааллын яамтай зөвшилцөн бүх Италийн хэмжээнд гол шаардлагатай бүс нутгуудад ажиллах эмч нарын зорилтот хүчийг сайн дурын үндсэн дээр бүрдүүлэх шийдвэр гарган 2020.03.20-ны өдрөөс бүртгэж эхлэхээр болжээ. Эмч нарын бүрэлдэхүүн хамгийн ихдээ 300 байх ба тэд эрүүл мэндийн бүтцийг дэмжих чиглэлээр ажиллана.
- **2020.03.20-нд Эрүүл мэндийн сайдын тушаалаар:**
 - Цэцэрлэгт хүрээлэн, зуслангийн байшин, олон нийтийн амралт зугаалгын газрууд, тоглоомын талбайд олноор цугларч тоглох, зугаалахыг хориглох,
 - мөн эмнэлэг, нисэх буудлын доторх хоолны газар, хүнсний худалдаанаас бусад энэ чиглэлийн үйл ажиллагаа, үйлчилгээг хаах,
 - Зайлшгүй шаардлагатай зөвшөөрөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээг наанадаж 1-1,5м-ийн зайтай байх нөхцөлийг бүрдүүлэх
 - Амралтын болон түүний өмнөх ба дараах өдрүүдэд шалтгаангүй бол өөрийн гэрээс өөр газарт зорчих хөдөлгөөнийг тус тус хориглосон. Эдгээр нь 2020.03.21-03.25 хүртэл хүчинтэй.

- **2020.03.22**-ны Эрүүл мэндийн яам болон Дотоод хэргийн яамны хамтарсан тушаалаар Тусгай ажлын шаардлага болон эрүүл мэндийн шалтгаантайгаас бусад тохиолдолд нийтийн болон хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосон.
- **2020.03.22**-ны өдрийн СнЗ-ийн ерөнхийлөгчийн зарлигаар хүнсний дэлгүүр, эмийн сан, ахуйн хэрэглээний дэлгүүр болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээнээс бусад үйлдвэрлэл, үйлчилгээнүүдийг хаасан. Энэ нь 2020.03.23-наас 04.03-ныг хүртэл хүчинтэй.

Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ⁴¹

Вирус тархахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх гаргасан зөвлөмж:

- Нийтийг хамарсан бүхий л үйл ажиллагааг түр зогсоох;
- Вирус өндөр тархалттай бүс нутгийг хэсэгчлэн болон бүх газар нутгаар хөл хорио тогтоох;
- Хүмүүс олноор цугларсан газар, агааржуулалт тааруу газраас зайлсхийх;

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:

- Бүх боомт, нисэх буудал, хяналтын цэгүүдэд халуун хэмжигч скайнер, эрүүл мэндийн хяналтын коридорыг ажиллуулсан.
- ДЭМБ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг дагах.
- 2020.03.21-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Италийн Ерөнхий сайд Контетай утсаар ярихдаа туслах санал тавьж Covid 19 эсрэг арга хэмжээнд халдваргүйжүүлэлт ариутгалын машин, төхөөрөмж, цэргийн эмнэлэг, вирус судлалын 100 орчим мэргэжилтнээс бүрдсэн 8 бригадыг илгээхээр болов.

Хилийн хяналт, зорчих хөдөлгөөний арга хэмжээ:

- Италийн Засгийн газрын болон Эрүүл мэндийн яамны ажлын хэсгийн хуралдаанаар Covid-19-ийн халдварын тархалтыг зогтоох, урьдчилан сэргийлэх зорилгоор 2020.01.31-нээс Итали Хятадын хооронд нислэгийг түр зогсоосон.
- Хятадтай нислэг түр зогсоосны дараа Эрүүл мэндийн болон Дэд бүтцийн яамдууд хамтран Гамшигтай тэмцэх нэгжийн дэргэд тусгай үйл ажиллагааны нэгж байгуулж, Хятад дахь италичууд, Итали дахь Хятадуудтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, ачаа тээвэр зохицуулах шийдвэр гаргасан.

⁴¹ <http://www.governo.it/it/articolo/coronavirus-conte-firma-il-dpcm-11-marzo-2020/14299> - СнЗ-ийн 2020.03.11-ний тогтоол. “Covid-19 халдварын тархалтыг зогсоох урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай”

**Эдийн засгийн үр
нөлөөг бууруулах
чиглэлээр авч буй
зарим арга хэмжээ**

2020.01.31-ний СнЗ-ийн хуралдаанаар: ДЭМБ-аас зарласан онцгой нөхцөл байдлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн санг баталсан.

2020.02.24-ний Засгийн газрын хуралдаанаар: Эдийн засаг ба санхүүгийн сайд Роберто Гуалтиери Улаан бүс хэмээгдэх хотуудад оршин суугч татвар төлөгчдийн үүргийн тухайд интервенц хийх шийдвэр гаргав.

2020.03.11-ний Засгийн газрын хуралдаанаар: Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр санал оруулсан нийт дүнг хэлэлцээд улсын төсвийн цэвэр тэнцэтгэлийг 2020 онд чадавхын хувьд 104.5 тэрбум еврогоор, бэлэн мөнгөний хувьд 154 тэрбум еврогоор, мөн төсөв олголтын чадавх болон бэлэн мөнгөний аль алины хувьд 25 тэрбум хүртэлх еврогоор тус тус өсгөх болов.

8.ОХУ

Эх сурвалж:

ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru>

ОХУ-ын Эрүүл мэндийн яамны цахим хуудас – <https://www.rosminzdrav.ru/ministry/covid19>

ОХУ-ын Харилцаа холбоо, мэдээллийн технологи, олон нийтийн харилцаа холбооны хяналтын алба (Роскомнадзор)-ны цахим хуудас – <http://rkn.gov.ru>

Москва хотын захирагчийн албаны цахим хуудас – <https://www.mos.ru>

Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/>

ОХУ-ын 2020.03.12-ны өдөр Засгийн газрын хуралдаанд Ерөнхий сайд Михаил Мишустиний ОХУ-д үүсэж буй эдийн засгийн нөхцөл байдлын талаар хэлсэн үгийг Хавсралтаар оруулав.

ОХУ	
Сүүлийн үеийн нөхцөл байдал	2020.03.23, 17:42 (Москвагийн цагаар) – Эрүүл мэндийн яам⁴²:
	<ul style="list-style-type: none"> • Нийт тохиолдол – 438 • Эмчлэгдсэн – 17
	<ul style="list-style-type: none"> • 2020.03.23-ний өдрийн байдлаар ОХУ-ын хилээр 69,932 хүн нэвтэрч эрүүл ахуй, хорио цээрийн хяналтад оржээ. • 2020.03.17-ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин тус улсын Засгийн газрын гишүүдтэй хийсэн ээлжит уулзалтын үед “Covid-19” вирус тус улсын 26 бүс нутагт 114 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс 104 нь импортолж, 10 нь контакт тохиолдол гэж мэдээлсэн байна.⁴³ • 2020.03.11-ний өдрийн ОХУ-ын Онц байдлын штабын мэдээ: ОХУ-д нийт 28 тохиолдол (Үүнээс 25 нь Италиас буцаж ирсэн ОХУ-ын иргэд, 2 нь БНХАУ-ын иргэд, 1 нь Итали Улсын иргэн) илэрсэн. БНХАУ-ын 2 иргэн, ОХУ-ын 1 иргэн, Diamond Princess хөлөг онгоцон дээр байсан ОХУ-ын иргэн, нийт 3 хүн эмчлэгдсэн. –Италиас буцаж ирсэн ОХУ-ын 25 иргэнээс “Covid-19” вирус илэрсэнтэй холбогдуулан сүүлийн 2 долоо хоногт Итали Улсад зорчсон бүх иргэдийг тогтоож тусгаарласан. Мөн ОХУ-ын нутаг дэвсгэрт тэдэнтэй холбоо тогтоосон хүмүүсийг тогтоож эмнэлгийн хяналтад авах ажил хийгдэж байна⁴⁴.

⁴² ОХУ-ын Эрүүл мэндийн яамны цахим хуудас – <https://www.rosminzdrav.ru/ministry/covid19> .

⁴³ Владимир Путин провёл очередное совещание с членами Правительства. 17 марта 2020 года, 16:40, Москва, Кремль.

Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://kremlin.ru/events/president/news/63001> .

⁴⁴ ОХУ-ын Онц байдлын штабын 2020.03.11 мэдээ. О решениях оперативного штаба по предупреждению завоза и распространения новой коронавирусной инфекции на территории России и подтверждённых случаях заболевания. **Эх сурвалж:** ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/news/39123/> .

ОХУ-ын Засгийн газраас авч байгаа гол арга хэмжээнүүд⁴⁵

-Зохицуулах зөвлөл,
Онц байдлын штаб,
- Эрүүл мэндийн яам,
-Роскомнадзор

Гадаадын иргэдийг ОХУ-ын нутаг дэвсгэрт оруулахыг түр хугацаагаар хязгаарлав:

–Хязгаарлалтад “Шереметьево” олон улсын онгоцны буудлын тусгай тоногдсон “F” терминалаар дамжих гадаад улсын нийслэл хотуудын тогтмол нислэгүүд, мөн заасан улс руу тухай орны иргэдийг хүргэх, тэндээс өөрийн иргэдийн авчрах тусгай үүргийн нислэгүүд хамаарахгүй.

–Хязгаарлалтад Хамтын нөхөрлөлийн улсууд, Абхаз, Өмнөд Осетийн иргэдэд хамаарахгүй.

- **2020.03.23**-ны өдрөөс эхлэн **гадаадын бүх улсаас** ирэх зорчигчдын 2 талын нислэгийг
- **2020.03.20**-ны өдрөөс эхлэн **Арабын Нэгдсэн Эмират Улсаас** ирэх зорчигчдын 2 талын нислэгийг
- **2020.03.18**-ны өдрөөс эхлэн **Беларус Улсын иргэд**, тус улсаас ирж байгаа гадаадын иргэдийг
- **2020.03.18**-ны өдрөөс эхлэн **гадаадын иргэдийг** (2020.05.01-нийг хүртэл)
- **2020.03.16**-ны өдрөөс эхлэн **Европын холбооны улсууд болон Швейцар, Норвеги** улсаас ирэх зорчигчдын 2 талын нислэгийг
- **2020.03.16**-ны өдрөөс эхлэн **гадаадын иргэдийг Орос-Польш, Орос-Норвегийн улсын хилийн хуурай замаар** (үүнд Беларусь Улсын иргэд хамаарахгүй)
- **2020.03.13**-ны өдрөөс эхлэн **Итали Улсын иргэд**, тус улсаас ирж байгаа гадаадын иргэдийг
- **2020.03.13**-ны өдрөөс эхлэн **Итали, Герман, Испани, Франц** улсуудын 2 талын нислэгийг
- **2020.03.07**-ны өдрөөс эхлэн **Иран Улсаас ирэх зорчигчдыг**
- **2020.03.01**-ны өдрөөс эхлэн **Солонгос Улсаас ирэх гадаадын иргэдийг**
- **2020.02.28**-ны өдрөөс эхлэн **агаарын тээврийн хэрэгслээр ирсэн Иран Улсын иргэдийг**
- **2020.02.20**-ны өдрөөс эхлэн **БНХАУ-ын иргэдийг**

Бусад арга хэмжээнүүд:

- **2020.03.23** – “Covid-19” вирусын улмаас өөрсдийгөө тусгаарлан гэртээ байгаа хүмүүст зориулж тус улсын Засгийн газар **үнэ төлбөргүй цахим үйлчилгээг** нэвтрүүлсэн байна. Үүнд:
 - цахим сүлжээний компаниуд, Харилцаа холбооны яамтай хамтран «[Все.онлайн](#)» нэгдсэн цахим сан,
 - мөн «[Культура.РФ](#)» соёлын хөтөлбөрийн цахим хуудсаар томоохон соёлын арга хэмжээг зохион байгуулж, шууд дамжуулахаар төлөвлөж байна.
- **2020.03.21** – ОХУ-ын Засгийн газрын нөөц сангаас халдварт **өвчнийг оношлох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан авахад** нийт 22.5 тэрбум рубль хуваарилсан.
- **2020.03.20** – Роскомнадзор нь Улсын ерөнхий прокурор, хууль сахиулах байгууллагуудтай хамтран коронавирустай холбоотой хуурамч мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.

⁴⁵ Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/>.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим сүлжээнүүдээс баталгаагүй, олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах эрсдэлтэй мэдээллүүдээ устгахыг шаардав.
- Тус байгууллага нь өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд худал мэдээлэл тараасан этгээдэд захиргааны арга хэмжээ авна.
- **2020.03.19** – Боловсролын байгууллагуудад халдварын эсрэг дэглэмийг дагаж мөрдөх, **шаардлагатай бол зайны сургалтад** шилжих арга хэмжээ авч эхэлсэн.
 - Боловсролын яамнаас алсын зайн сургалтыг зохион байгуулах, дэмжих нэгдсэн журам боловсруулах ажлын хэсэг байгуулсан.
- **2020.03.19** – Эмнэлгийн байгууллагуудад эмийн жорыг цахим хэлбэрээр олгохыг Эрүүл мэндийн сайдын 2020.03.19-ний өдрийн №198н тушаалаар үүрэг болгов.
 - Эрүүл мэндийн яамнаас бүс нутгийн анхан шатны эмч нар архаг өвчтэй иргэдэд **3 хүртэл сарын хүчинтэй жор** олгохыг зөвлөж байна.
 - “Covid-19” вирусын халдвар тархаж байгаатай холбогдуулан архаг өвчтэй иргэд, ахмад настнууд нийтийн тээврээр зорчих, олон нийтийн газар (дэлгүүр, клиник орно) зочлохыг багасгаж, шаардлагатай бол гэрээсээ эмчид хандахыг зөвлөж байна.
- **2020.03.18** – Зарим эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлийн тусгай журам тогтоосон:
 - мэс заслын болон үзлэгийн хамгааллын хувцас, хэрэгсэл, нийт 36 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийн улсын бүртгэлийн тусгай журам тогтоосноор халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг эргэлтэд оруулах боломжтой болно гэж үзэж байна.
- **2020.03.18** – “Covid-19” вирусын халдвар авсан иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа, халдвар авах эрсдэлтэй хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхэд Засгийн газрын нөөц сангаас **11.8 тэрбум рубль** олгохоор болсон байна.
- **2020.03.17** – Москва хотод “Covid-19” вирус өвчний талаархи мэдээллийн төв нээгдэв.
 - Төвийн үндсэн үүрэг бол коронавирусын эсрэг авч буй арга хэмжээний талаар холбооны болон бүс нутгийн удирдлагуудын уялдаа холбоог хангах явдал юм.
 - Төв нь олон нийтийн сүлжээнд хэвлэгдсэн мэдээллийг боловсруулах, найдвартай байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, хуурамч мэдээлэл олж илрүүлэх, вирус дэлхийн хэмжээнд тархсан тухай албан ёсны мэдээллийг цуглуулна.
- **2020.03.16** – “Covid-19” вирусын шинэ халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэхэд эмнэлгийн байгууллагуудын ажлыг зохион байгуулах түр журам” (Эрүүл мэндийн сайдын 2020.03.16-ны өдрийн №171 тушаал)-ыг Холбооны субъектуудад хүргүүлэв. Үүнд:
 - насанд хүрэгчид, хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд “Covid-19” вирусын халдварт өвчний оношлогоо, эмчилгээний талаархи зайнаас зөвлөх төвүүдийг байгуулав,
 - эмнэлгийн ажилтнуудын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Холбооны төвүүдийн дуудлага хүлээн авах нэгдсэн утасны дугаартай болов,

- Фтизиопульмонологи ба халдварт өвчин судлалын эрдэм шинжилгээ, судалгааны төвийн мэргэжилтнүүд бүс нутгийн эмнэлгийн ажилчдад зориулж зайн сургалт, семинар, 24 цагийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна.
- **2020.03.14** – “Covid-19” вирусн сэжигтэй шалтгаанаар хорио цээрийн дэглэмд байгаа иргэдэд тусгай журмаар өвчний лист олгоно.
 - “Covid-19” вирусн халдварын эсрэг ажиллаж байгаа эмч нарыг шагнах сан байгуулсан.
- **2020.03.14** – Засгийн газрын дэргэд ОХУ-д “Covid-19” вирусн халдвар тархахтай тэмцэх **Зохицуулах зөвлөлийг байгуулж**, Зөвлөлийн үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнийг баталсан байна. Зохицуулах зөвлөлийг ОХУ-ын Ерөнхий сайд удирдана.
- **2020.03.14** – ОХУ-ын Ерөнхий сайд тус улсад “Covid-19” вирусн халдвар тархахтай тэмцэх **багц арга хэмжээний батлав**.

Цаашид авч хэрэгжүүлэхээр бэлтгэлгэж байгаа бусад арга хэмжээнүүд:

- **2020.03.23 – Эрсдэл бүлгийн иргэдэд чиглэсэн:**
 - 45 ба түүнээс дээш настай, 65 ба түүнээс дээш настай, 80-аас дээш настай иргэдийн тоог, мөн тэднээс архаг өвчлөл, ялангуяа зүрх судасны өвчин, чихрийн шижин өвчтэй эсэхийг тогтоохоор ажиллаж байна. Олж авсан мэдээллийг харгалзан үзэж, энэ ангиллын иргэдийн хяналтыг сайжруулах, хүнд нөхцөлд байгаа тохиолдолд бүх төрлийн тусламж үзүүлэх зорилгоор эмнэлгийн байгууллагуудтай ажиллах алгоритм боловсруулахаар ажиллаж байна.
 - Сайн дурынхныг энэ ажилд татан оролцуулахаар ажиллаж байна.

Москва хотын захиргаанаас авч байгаа арга хэмжээ

Москва хотын захирагч С.Собянин улсын хилийг бүрэн хаах боломжгүй тул вирус зөөвөрлөгдөн орж ирэх магадлал өндөр хэвээр байна, “Covid-19” вирусний халдвар авах таагүй нөхцөл үүссэн орнуудаас ирж буй иргэдээс **урьдчилан сэргийлэх үзлэг, хяналт тавих шаардлагыг улам бэхжүүлнэ** хэмээн мэдэгдэв.⁴⁶

- Москва хотын захирагч С.Собянин эрүүл мэнд, нийтийн тээвэр болон аж ахуйн ажилтан албан хаагчдыг 2020.03.05-ны өдрөөс эхлэн **ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДАЛД ШИЛЖҮҮЛЭВ**.
- Москва хотын захирагч хорио цээрийн үр дагаврыг албан ёсоор **ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ** гэж зарласан.
- Москва хотын гудамжинд 2020.04.10-ны өдрийг хүртэл олон нийтийн арга хэмжээ, 50-иас дээш хүн цугларч чөлөөт цагаа өнгөрөөхийг хориглосон.
- 2020.03.26-ны өдрөөс 04.14-ний өдрийг хүртэлх хугацаанд 65-аас дээш насны болон архаг өвчтэй иргэдийг хорио цээрийн дэглэмд заавал байхыг үүрэг болгов.

⁴⁶ Коронавирус. О дополнительных мерах по предотвращению распространения инфекции.

Эх сурвалж: Москва хотын захирагчийн цахим хуудас - <https://www.sobyanin.ru/koronavirus-o-dopmerah-po-predotvrascheniyu-rasprostraneniya-infektsii> .

- Улсын сургууль, нийслэлийн боловсролын газрын харьяа коллеж, спорт сургууль, нэмэлт боловсролын байгууллагуудын хичээлийг 2020.03.21-ний өдрөөс 04.12-ны өдрийн хооронд хичээлүүдийг цуцлав.
 - Энэ хугацаанд сурагчдын тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй зорчих картыг түр түдгэлзүүлэв.
 - Сурагчид Москвагийн цахим сургуулийг ашиглан гэртээ хичээлийн хөтөлбөрөө үргэлжлүүлэн эзэмшинэ. Хотын коллежууд оюутнуудын зайн сургалтыг зохион байгуулна.
 - Эцэг эхчүүдэд хүүхдүүдээ хорио цээрийг зөрчин олон нийтийн газар гарч ирэхгүй байхыг зөвлөж байна.
 - Үнэгүй хооллох эрхтэй бүх оюутнуудад энэ хугацаанд хүнсний иж бүрдэл өгч байна.
 - Эцэг эхийн хүсэлтээр 1-4 дүгээр ангийн сурагчдын хичээлийг 12-аас илүүгүй сурагчидтайгаар хийж болно. Хичээлийн өмнө хүүхдүүдийн температурыг хэмжих ба сургуулийн байрыг тогтмол халдваргүйжүүлнэ.
 - Сургуулийн өмнөх бүлгүүд хэвийн ажиллах ба эцэг эх нь хүүхдээ цэцэрлэгт авчрах эсэхийг шийднэ.
 - Олон нийтийн газарт халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг нэмэгдүүлсэн. Үүнд:
 - Худалдаа, үйлчилгээний газрууд, соёл, спорт, хүн амын нийгмийн хамгаалал, боловсрол, бусад байгууллагуудад чийгтэй цэвэрлэгээг илүү олон хийж, хэт ягаан туяаны цацраг туяагаар агаар, агааржуулагч, агааржуулалтын системийг ариутгаж байна.
 - Нийтийн тээвэрт чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна. Тухайлбал, метроны тасалбар худалдах машиныг цаг тутамд цэвэрлэж байна. Метроны галт тэрэгний дотор агаарыг зөөврийн хэт ягаан туяаны гэрлээр цэвэршүүлж, агаар шүүлтүүрийг илүү олон удаа сольж байна.
 - Москвад жижиглэн худалдааны үлдэгдэл болон үнийн талаархи цахим мониторинг зохион байгуулав.
 - Дэлгүүрүүдэд бараа бүтээгдэхүүн тасалдалгүй байх шаардлагатай арга хэмжээг авч байна.
 - Москва хотын засаг захиргаа өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан хөдөлгөөн нь хязгаарлагдмал байгаа иргэд, ААН-үүдэд болон нийгмийн зорилтот бүлэгт зориулсан нэмэлт арга хэмжээ боловсруулж байна.
 - Нийтийн тээврийн зорчигчид болон поликлиникийн өвчтөнүүдийн биеийн халууныг тогтмол хэмжиж байна.
 - “Covid-19” вирусний өвчлөл гарсан орноос ирж буй иргэд аяллын бүртгэлд хамрагдах ба 14 хоногийн турш гэртээ өөрийгөө тусгаарлан эмчийн зөвлөгөөг дагахыг үүрэгжүүлэв.
 - Москва хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуй нэгж, байгууллагууд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгав. Үүнд:
 - ажилагсдын биеийн халууныг ажлын байран дээр тогтмол хэмжих, халуунтай хүнийг тусгаарлах,
 - гэртээ өөрийгөө тусгаарлах боломжоор хангах,
 - “Covid-19” вирус илэрсэн хүний бүх холбоотой хүмүүсийн мэдээллийг авах, өвчтөн байсан газрыг халдваргүйжүүлэх.
 - Москва хотын эрүүл мэндийн газарт зарим хүнд өвчтэй болон 60-аас дээш насны хүмүүст гэрт нь эмнэлгийн тусламж үзүүлэхийг даалгав.
-

- Эмнэлгийн байгууллагуудад бэлэн байдлаа хангахыг даалгав.
- Дараагийн мэдэгдэл гарах хүртэл Онц байдлын штаб 24 цагаар ажиллана.

Авч хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээнүүд ⁴⁷

- 1) Олон нийтийн арга хэмжээнүүдийг 2020.04.10-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хориглов. Тухайлбал, Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн форум, Красноярскийн эдийн засгийн форум, Сочийн Хөрөнгө оруулагчдын форум, Ялтын эдийн засгийн форумуудыг цуцалсан байна⁴⁸.
- 2) Москва хотын нисэх онгоцны буудлуудад эмнэлгийн пост ажиллуулж байна. Хятад, Иран, Өмнөд Солонгос улсуудаас ирсэн бүх иргэдийг тусгаарлах, асуумж бөглүүлэх, гэрэл зураг авах, “Covid-19” вирусний шинжилгээ авч байна. Шаардлагатай тохиолдолд эмч нар тэдэнд эмнэлгийн чөлөө өгнө. –“Covid-19” вирусний халдвар авах таагүй нөхцөл байдалтай Итали болон бусад орноос буцаж ирсэн иргэд (мөн халдварын шинж тэмдэггүй жуулчид) Москва хотын даргын захирамжийн дагуу тусгай +7(495)870-45-09 дугаарт **буцаж ирсэн тухайгаа мэдээлэх үүрэгтэй**. Мөн тэд 2 долоо хоногийн турш гэртээ хорио цээрийн дэглэмд байна. Тэдэнд эмнэлгийн чөлөөг гэрт нь шууд хүргэж байна.
- 3) Олон улсын нисэх онгоцны буудлын бүх зорчигчдын биеийн халууныг хэмжиж байна.
- 4) Хотын эмнэлгүүдэд “Covid-19” вирусний халдвар авсан байж болзошгүй өвчтөнүүдийг хэвтүүлэх нэмэлт эмнэлгүүдийг бэлтгэсэн.
- 5) Цэцэрлэг, сургуулиудад хүүхдүүдийн температурын өдөр бүр хэмжиж байна.
- 6) Москва хотын метроны буудлуудад алсын зайнаас биеийн халуун хэмжигчийг байрлуулсан.
- 7) Халдварын тархацын янз бүрийн хувилбарт шуурхай авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.**

Хорио цээрийн дэглэм зөрчсөн этгэдэд хүлээлгэх хариуцлага	Хорио цээрийн дэглэм зөрчиж, тусгаарласан газраас дур мэдэн гарсан этгээдэд Эрүүгийн хуулийн 236 дугаар зүйл буюу “Эрүүл ахуй халдваргүйжүүлэлтийн дэглэм зөрчих” гэсэн үндэслэлээр хариуцлага хүлээлгэнэ. Уг хэрэг нь нийгэмд учруулсан хор уршгаасаа хамаарч 80 мянган рубль (3.6 сая орчим төгрөг) хүртэлх мөнгөн торгууль оноох болон 5 хүртэлх жилийн хорих ялтай аж. ⁴⁹ <ul style="list-style-type: none"> ○ Москва хотод видео камераар хорио цээрийн дэглэмд хяналт тавьж байна.
Эдийн засгийн байдал	2020.03.19 – Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн түрээсийн төлбөрийг 2020 онд түр хойшлуулав. ⁵⁰

⁴⁷ Контроль ситуации в Москве. **Эх сурвалж:** Москва хотын захирагчийн албаны цахим хуудас – <https://www.mos.ru/city/projects/covid-19/#rec167197919> .

⁴⁸ Шинэ коронавирус (Covid-19)-т халдвартай холбоотой нөхцөл байдлын талаар.

Эх сурвалж: Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09

⁴⁹ **Эх сурвалж:** Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09.

⁵⁰ Распоряжение Правительства РФ от 19.03.2020 № 670р. **Эх сурвалж:** ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/> .

2020.03.17 – Шинэ коронавирусын халдвар тархаж байгаатай холбогдуулан нөхцөл байдал улам хүндэрсэн тохиолдолд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлав.

2020.03.18 – 2020 онд гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй тур оператор компаниудын нөөц санд оруулах шимтгэлийн хэмжээ 1 рубль байхаар шийдвэрлэв.⁵¹

2020.03.12 – ОХУ-ын Төсвийн байнгын хорооны дарга Алексей Кудрин “Covid-19” вирусний *тархалт дэлхийн эдийн засагт ямар хэмжээнд сөргөөр нөлөөлөхийг одоо хэлэх боломжгүй. Урьдчилсан байдлаар дэлхийн эдийн засгийн өсөлт 0.4 пунктээр, ОХУ-ын эдийн засгийн өсөлт 0.1-0.2 пунктээр буурч магадгүй. Энэ бол урьдчилсан таамаглал, 2 сарын дараа арай бодитой тооцоо хэлж болох юм*” гэжээ.⁵²

⁵¹ Распоряжение Правительства РФ от 18.03.2020 № 660р. **Эх сурвалж:** ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/docs/> .

⁵² **Эх сурвалж:** Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09.

9.ФРАНЦ /2020.03.18-ны байдлаар/

Эх сурвалж:

- БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus>
- Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662>

Франц ⁵³	
Сүүлийн үеийн нөхцөл байдал	<p>2020.03.12, 19:30 (Парисын цагаар) – БНФУ-ын Засгийн газрын мэдээ⁵⁴:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт тохиолдол – 2876 (2020.01.24-ний өдрөөс хойших) • Нас барсан хүний тоо – 61 –Нас барсан анхны тохиолдол 2020.02.14-ний өдөр бүртгэгдсэн байна. • Засгийн газар “Covid-19” вирусний тархалтыг хязгаарлах шинэ арга хэмжээ авах, эрүүл мэндийн хямралаас урьдчилан сэргийлэх, эмчлэх төлөвлөгөөний 2-р үе шатанд явж байна. • “Эмнэлгийн ажилтнууд, байгууллагууд нөхцөл байдлын талаар шуурхай мэдэгдэж, Францад тохиолдож болзошгүй хэргийг хэрхэн зохицуулах талаар зөвлөмж гаргасан тул Францын бүх эрүүл мэндийн систем энэ өвчнийг эмчлэхэд бэлэн байна” хэмээн тус улсын Засгийн газрын цахим хуудсанд мэдэгдсэн байна. • Ерөнхий сайд Э.Макрон тус улс “Covid-19” вирусний голомтот халдварын цэг болох нь “гарцаагүй” боллоо хэмээн мэдэгджээ. (2020.03.09)⁵⁵ • Үндэсний ассамблейн доод танхимын 4 гишүүн өвчний халдвар авсан нь тогтоогдсон. (2020.03.09)⁵⁶
БНФУ-ын Засгийн газраас авч байгаа зарим арга хэмжээ	<p>03.12 – Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндээ хамгаалах зөвлөмжүүдээ тогтмол боловсруулан иргэдээ зөвлөж байна (<i>“Covid-19” вирус авсан хүмүүс болон энэ вирус тархсан газарт амьдардаг иргэдэд өгч байгаа зөвлөмж</i>” хэсгээс харна уу)</p> <p>03.09 – Өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбоотойгоор эмнэлгийн хамгааллын хэрэгслийн экспортод хязгаарлалт тогтоов.</p> <p>03.08 – Ач холбогдолгүй 1000-аас дээш хүний цуглаан хийхийг хориглов.</p>

⁵³ Informations Coronavirus. **Эх сурвалж:** БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus> .

⁵⁴ Informations Coronavirus. **Эх сурвалж:** БНФУ-ын Засгийн газрын цахим хуудас – <https://www.gouvernement.fr/info-coronavirus> .

⁵⁵ Шинэ коронавирус (Covid-19)-т халдвартай холбоотой нөхцөл байдлын талаар.

Эх сурвалж: Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын цахим хуудас - <https://gia.gov.mn/53/item/662> . Огноо - 2020-03-09

⁵⁶ Мөн тэнд.

- 03.06** – Гидро спирт (hydro-alcoolique)-тэй гелийн **борлуулалтын үнийг** тогтоох тогтоолыг нийтлэв.
– Эмнэлгүүдэд цагаан төлөвлөгөө, асрамжийн газруудад цэнхэр төлөвлөгөөг идэвхжүүлэв.
- 02.29** – “Covid-19” вирусний эсрэг Батлан хамгаалах зөвлөл болон БНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Сайд нарын онцгой зөвлөл хуралдав. Вирусний тархалтыг хязгаарлах шинэ арга хэмжээ авах, эрүүл мэндийн хямралаас урьдчилан сэргийлэх, эмчлэх төлөвлөгөөний 1-р үе шатнаас 2-р үе шатанд шилжих үйл явцыг албан ёсоор баталсан байна.
– Хязгаарлагдмал орон зайд 5000-аас дээш хүний цугларалт хийхийг хориглов.
- 02.28** – “Covid-19” вирусний **“давагдашгүй хүчин зүйл”** гэж зарлав.
- 02.24** – Биологийн оношилгооны чадварыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэдэн сая нэмэлт FFP2 амны хаалт захиалав.
- 02.24** – SAMU-ийн төв штабын байранд 70 эмнэлгийн байгууллага, нийт 107 эмнэлгийн байгууллага “Covid-19” вирусний бүхий өвчтөнүүдийг хүлээн авах бэлтгэлээ хангасан байна.
- 02.19** – Үхань хот, Хүбэй мужийн эмнэлгүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмжийг эв нэгдлийн бэлэг тэмдэг болгон ачуулжээ. Энэ нь эрүүл мэндийн хамгаалалтын хувцас, амны хаалт, бээлий, ариутгалын бодис бүхий 17 тонн ачаа болсон байна.
- 02.17** – Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан практик гарын авлага илгээв.
- 02.13** – Францад “Covid-19” вирусний идэвхтэй тархах бэлтгэлийг хангахын тулд эрүүл мэндийн тогтолцоог дайчлах ажлыг зохион байгуулах зорилготой ORSAN төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэв.
Энэхүү төлөвлөгөөний зорилго нь Францад “Covid-19” вирусний идэвхтэй тархалтын бэлтгэлд эрүүл мэндийн тогтолцоог дайчлах ажлыг зохион байгуулах явдал юм.

Эрүүл мэндийн чиглэлээр авч байгаа арга хэмжээ

- Олон улсын нисэх онгоцны буудлуудад Хятад, Хонконг, Макао руу нисэх онгоцны буудалд зорчигчдыг хүлээн авах тусгай үйлчилгээ байгуулагдаж ажиллаж байна.
 - Олон улсын нисэх онгоцны буудлуудад “Covid-19” вирус тархсан газар нутгаас буцаж ирж байгаа зорчигчдод заавар, зөвлөмжийн дагуу хяналт тавин ажиллаж байна.
 - Эв санааны нэгдэл, эрүүл мэндийн яам нь батлагдсан тохиолдол бүрийг нэн даруй мэдээлэх үүрэгтэй боловч шалгаж буй хэргийн талаар (сэжигтэй хэрэг, шалгалтын явцад гарсан тохиолдол гэх мэт) мэдээлэл өгдөггүй гэсэн байна.
 - Европ, Гадаад харилцааны яам
-

–олон улсын эпидемиологийн нөхцөл байдал, ДЭМБ-ын зөвлөмжийг тусган “Covid-19” вирус тархсан улс орнуудад аялагч хүмүүст өгч байгаа зөвлөмжөө шинэчилсэн байна;

–халдварт өвчний голомт болсон Хүбэй мужид амьдарч байсан Франц, Европын иргэдийг эх орондоо буцаах үйл ажиллагааг 4 удаа зохион байгуулсан. Ийнхүү буцаж ирсэн бүх францчууд ирснээс хойш 14 хоног тусгаарлагдсан ба энэ үед эрүүл ахуйн дүрмийг хатуу мөрдөж ажиллажээ.

- “Covid-19” вирус нь оюутан, сургуулийн ажилтан, сургуульд нөлөөлсөн бол эрдэм шинжилгээний үйлчилгээнд нэн даруй мэдэгдэх шаардлагатай. Ингэснээр сурагч, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах бүхий л арга хэмжээг бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран хийнэ. Нөлөөлөлд өртсөн сургуулиуд түр хугацаагаар хаагдана.

“Covid-19” вирус авсан хүмүүс болон энэ вирус тархсан газарт амьдардаг иргэдэд өгч байгаа зөвлөмж

- өдөрт 2 удаа биеийн халуунаа хянах;
- амьсгалын замын халдварын шинж тэмдэг (ханиалгах, амьсгал давчдах гэх мэт)-ийг ажиглах;
- гараа тогтмол угаах, эсвэл усан архины уусмал хэрэглэх;
- сул дорой хүмүүстэй (жирэмсэн, архаг өвчтэй, өндөр настан гэх мэт) холбоо барихаас зайлсхийх;
- эмзэг бүлгийн хүмүүс (эмнэлэг, амаржих газар, ахмад настнуудын амьдрах орон сууц гэх мэт)-рүү байнга очихоос зайлсхийх;
- шаардлагагүй бол гэрээсээ гадуур гарахаас зайлсхийх (томоохон цуглаан, ресторан, кино театр гэх мэт);
- ажилчид / оюутнууд: шинж тэмдэг илрээгүй тохиолдолд та ажилдаа буцаж очих боломжтой;
- хүүхдүүд, дунд, ахлах ангийн сурагчдыг цэцэрлэг, сургууль, ахлах сургууль, коллежид явуулж болно;
- “Covid-19” вирусний талаар мэдээллийг 0 800 130 000 гэсэн төлбөргүй утас руу залгаж авах;
- хэрэв та амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрсэн (халуурах, эсвэл халуурах мэдрэмж, ханиалгах, амьсгал давчдах), вирус тархсан газар амьдардаг, эсвэл вирус тархсан бүсээс буцаж ирснээс хойш 14 хоногийн дотор дараах арга хэмжээнүүдийг авах:
 - шинж тэмдгийн талаар мэдээлэхийн тулд Samu Centre-ийн 15 дугаараар (**ярианы болон сонсголын бэрхшээлтэй хүмүүс** 114 дугаараар) холбоо барьж байна;
 - бусадтай холбоо барихаас зайлсхийх,

Эдийн засгийн чиглэлээр авч байгаа арга хэмжээ

- Төрийн худалдан авах гэрээ байгуулсан компаниудыг хүргэлт хойшлогдсон тохиолдолд **торгууль ногдуулахгүй**.

- 2020.03.02-ны өдрөөс эхлэн Хөрөнгө оруулалтын банк (BPI) нь энэ хүнд хэцүү үед тэднийг дэмжих зорилгоор ЖДҮ эрхлэгчдийн хүссэн бүх зээлийг баталгаатай гаргаж байна.
- **Эдийн засгийн тогтвортой байдлын алба** 2020.03.03-ны өдөр Эдийн засаг, сангийн яаманд байгуулагдав. Энэхүү нэгж нь тус улсын эдийн засагт үзүүлэх эрүүл мэндийн хямралын үр дагаврыг даван туулахын тулд улс орны эдийн засгийн байдлын талаарх шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой.
- Эдийн засаг, сангийн яамнаас дараах арга хэмжээг зарлав:
 - ноцтой хүндрэл бэрхшээлтэй тулгарах, ялангуяа нийгмийн болон татварын хураамжийг хэсэгчлэн ашиглах, хуваарилахтай холбоотой компаниудад тохиолдсон тохиолдол бүрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;
 - БНХАУ-ын мужуудад үйл ажиллагаа, ложистикийн нөхцөл байдлын талаар хэрэгтэй бүх мэдээллийг өгч байгаа;
 - нийлүүлэлтийн шинэ эх үүсвэр, ялангуяа барилга, химийн тодорхой салбаруудад баталгааны журмыг хурдасгах, байгаль орчны болон бусад стандарт, Европын стандартад нийцүүлэн хангамжийн эх үүсвэрээ төрөлжүүлэхэд нь түсэлж байна;
 - зарим стратегийн салбарууд, тухайлбал, автомашины салбарыг гадаадад хүргэх үйл ажиллагааг хараат бус болгохын тулд хангамжийн талаар төлөвлөгөө боловсруулах шаардлагатай;
 - Францын банкны менежерийн хамт орон нутаг дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор зээлийн зуучлалыг сэргээхээр шийдсэн бөгөөд эдгээр нь гэрээгээ хянаж, зээлээ эргэн харах шаардлагатай байна.
- Covid-19” вирус нэрвэгдсэн компаниудад үзүүлэх тусламжийн системийг хялбарчлах:
 - Компаниуд нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах хүсэлтийг ердөө л цахимаар илгээх боломжтой байх;
 - “Covid-19” вирусний эдийн засгийн нөлөөллөөс болж устгах аюулд өртөж буй ААН-үүдэд татварын шууд хөнгөлөлт үзүүлнэ;
 - Хөдөлмөрийн яамтай холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийг хадгалахын тулд хэсэгчилсэн үйл ажиллагааны тогтолцоог бэхжүүлэх, хялбаршуулах (хариу арга хэмжээ 48 цаг, маш жижиг ААН-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд үзүүлэх тэтгэмжийг нэмэгдүүлэх).

Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай

Тус улсад хотын болон орон нутгийн сонгууль 3 дугаар сарын 15, 22-ны өдрүүдэд болно.

- Сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдал, чин сэтгэлийн байдлыг хангах үүднээс Дотоод хэргийн сайд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч баталгааг гаргасан байна.

**холбоотой авч
байгаа арга хэмжээ**

- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сонгогчдын болон санал авах байранд сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах гишүүдийн эрүүл мэндийг хангахад чиглэсэн байна.
 - Санал авах бүх байрны дотоод зохион байгуулалтыг төлөвлөхдөө уг байранд удаан хугацаагаар зөвшөөрөлгүй байхаас зайлсхийхээр хийсэн байна.
 - Сонгогчдод болон сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах гишүүдэд зөвлөгөө өгч байна. Үүнд:
 - халдваргүйжүүлэх хамгийн үр дүнтэй арга болох гараа савантай усаар угаах бөгөөд санал авах бүх байруудад гараа угааж байх усан хангамжийн цэг байх ёстой:
 - гараа угаах хамгийн ойр цэг дээр тэмдэг байрлуулах;
 - хэрэв боломжгүй бол ус, согтууруулах ундааны уусмал байрлуулах;
 - натрийн гипохлорит (цайруулагч) дээр суурилсан цэвэрлэх уусмалыг ашиглах зөвлөмжийн дагуу санал авахаас өмнө, дараа нь санал авах байрыг цэвэрлэх;
 - санал авах байранд Францын эрүүл мэндийн эмблем бүхий зурагт хуудас байрлуулах.
-

10.ЯПОН

Эх сурвалж:

- Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/newpage_00032.html
- Японы Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яам, <https://www.meti.go.jp/english/covid-19/index.html>
- Японы Гадаад хэргийн яам, https://www.mofa.go.jp/ca/fna/page4e_001051.html
- Японы хэвлэл, мэдээллийн цахим хуудсууд www.nhk.or.jp, www.nippon.com, www.japantimes.co.jp

Япон	
Нөхцөл байдал	<p>2020.03.25, 12:00 цагийн байдлаар</p> <p>Нийт бүртгэгдсэн тохиолдол –1193</p> <ul style="list-style-type: none"> • Нас барсан хүний тоо – 43 (Diamond Princess хөлөг онгоцны зорчигсдоос халдвар авсан хүний тоо – 712; эмнэлгээс гарсан – 590, эрчимт эмчилгээнд – 11, нас барсан – 10 хүн) <ul style="list-style-type: none"> ○ 2020.02.27-нд БНХАУ-ын Ухань хотоос өөрсдийн 800 гаруй иргэнийг 5 тусгай үүргийн нислэгээр эх оронд нь авчирсан. <p>Хууль тогтоомжийн тухайд:</p> <ul style="list-style-type: none"> • “Онц байдал зарлах” хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд “Шинэ төрлийн ханиад, томууны эсрэг тусгай арга хэмжээ авах хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг 10-ны өдөр Парламентдаа өргөн барьж, улмаар 13-ны өдөр баталсан. Ингэснээр коронавирусний халдвар улс оронд хурдан тархаж, хүмүүсийн амьдрал, эдийн засагт ноцтой нөлөөлөх нөхцөл үүсэх бол Ерөнхий сайд онц байдлыг хоёр жил хүртэл хугацаагаар зарлах эрхтэй болж байгаа юм. Онц байдал зарлагдсаны дараа мужийн захирагчид оршин суугчдыг гэртээ байхыг шаардаж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох, олон нийтийн арга хэмжээ цуцлах, хойшлуулах зэрэг эрхтэй болно. Мөн орон нутгийн засаг захиргаа эм, хоол хүнс зэрэг зайлшгүй шаардлагатай материалыг тэдэнд зарахыг шаардаж болно. Тэд эмнэлгийн тусламж үзүүлэх зорилгоор хувийн газар, байгууламжийг түр хугацаагаар ашиглах эрхтэй болно.⁵⁷ • 2020.03.12-нд Ерөнхий сайд Ш.Абе коронавирусний халдварын тархалтыг <i>state of historic emergency</i> буюу “түүхэн онц байдал” гэж зарласан бөгөөд ингэснээр халдвартай холбоотой Засгийн газрын хуралдааны

⁵⁷ <https://www.mhlw.go.jp/content/10900000/000606693.pdf>

тэмдэглэл, тов, агуулга, илтгэгч нарын мэдээллийг заавал баримтжуулж, бүртгэх юм. Энэхүү заалтыг 2012 онд батлагдсанаас хойш анх удаа хэрэглэж байгаа юм.⁵⁸

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай:

- Амны хаалтны хомсдол үүссэнтэй холбогдуулан Японы өөрийн хамгаалах хүчний нөөцөөс 350 000 амны хаалтыг Засгийн газарт 2020.03.12-ны өдөр хүлээлгэн өгөв.⁵⁹
- **Японы Засгийн газрын 2020.03.10-ны өдрийн хуралдаанаар:**
2020.03.15-ны өдрөөс эхлэн **амны хаалт дамлан худалдаалахыг** (худалдаж авсан үнээс давуулж зарах) хориглож, зөрчсөн **тохиолдолд 3 сая хүртэл иенийн (28.5 мянган ам.доллар) торгууль, эсхүл жил 5 хүртэл хугацаагаар хорих ял** оногдуулахаар шийдвэрлэсэн.

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүд

2020.02.25-нд Шинэ коронавирусний халдварыг хянах төв штабаас:

“Basic Policies for Novel Coronavirus Disease Control”⁶⁰ /Шинэ коронавирусний халдварыг хянах Үндсэн бодлого/-ийг гаргасан. Энэхүү баримт бичиг нь одоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид үүсэх нөхцөл байдлын хариу арга хэмжээнүүдийг нэгтгэсэн баримт бөгөөд өвчтөний өсөлтийн түвшинг бууруулах, тархалтыг багасгахын зэрэгцээ тархалтыг эрт зогсоох, хүнд тохиолдлуудыг багасгах, Японы нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгахад чиглэгдэж байна.

Тус баримтыг үндэслэн яам, агентлагууд хоорондоо хамтран ажиллаж, тодорхой арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ. Үндсэн бодлогыг шинээр үүсэж буй нөхцөл байдал, эсхүл шинэ шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл дээр үндэслэж шинэчилнэ.

Халдварын хяналтын тухай хуулийн дагуу шинэ төрлийн коронавирусний халдварт өвчнөөр халдварлагдсан байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд үзлэг шинжилгээнд хамруулна.

Хэрэв халдварын тохиолдол нь батлагдсан бол холбогдох хуулийг үндэслэн тархвар судлалын идэвхтэй судалгаа хийж, халдвар авсан хүнтэй харьцсан хүмүүсийг тогтооно.

Халдвар авсан хүнтэй харьцсан хүмүүсийн хувьд халдварын тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд өөрийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих, өөрийгөө тусгаарлах арга хэмжээг авна.

⁵⁸ <https://thediplomat.com/2020/03/japan-takes-additional-measures-to-fight-coronavirus-outbreak/>

⁵⁹ <https://www.nippon.com/en/news/ntv20200312003/coronavirus-sdf-delivers-350-000-masks-to-govt.html>

⁶⁰ <https://www.mhlw.go.jp/content/10200000/000603611.pdf>

Баримтын товч агуулга:⁶¹ **Иргэд, хувийн сектор, бүс нутгуудад мэдээлэл түгээх чиглэлээр:**

- Үнэн зөв, тодорхой мэдээлэл түгээж, тайван хариу үйлдлийг хөхүүлэн дэмжих;
- Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ажлаасаа чөлөө авах, зайнаас ажиллахыг хөхүүлэн дэмжих;
- Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах шаардлагыг эргэн харах;
- Вирус тархсан улс оронд байгаа Япон Улсын иргэдэд мэдээлэл өгч, туслалцаа үзүүлэх;
- Олон нийт, гадаадын Засгийн газар, гадаад жуулчдад зөв зохистой, түргэн шуурхай мэдээлэл түгээх.

Япон дахь халдварын нөхцөл байдлын талаарх ойлголт:

- Коронавирусний халдварыг оношлох PCR оношилгоонд анхаарлаа төвлөрүүлж, эмнэлэгт хэвтэхийг шаарддаг уушгины хатгалгааны өвчтөнүүдийн оношийг бататгах, Японд тархсан халдварт өвчний хяналтын системийг бэхжүүлэх.

Халдварыг хяналтад авах арга хэмжээ:

- Өвчтөний тоо нэмэгдсэн газар, бүсэд иргэдийг олон нийтийн газар явахгүй байхыг сайн дураар татгалзахыг уриалах.
- Орон нутгийн удирдлагаар дамжуулан, сургуулиудын удирдлагуудад сургуулиудыг үйл ажиллагааг түр зогсоох зэрэг холбогдох арга хэмжээ авахыг уриалах.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд гаргасан зөвлөмж:

- Шинэ корона вирусний халдварын сэжигтэй өвчтөнүүдийг нэгдсэн эмнэлэгт хүлээн авахын өмнө халдварын хяналтын арга хэмжээг авсан байх, бага зэргийн томуу хэлбэрийн шинж тэмдэг бүхий өвчтөнүүд гэрээр эмчлүүлэх. Ахмад настан, суурь өвчтэй хүмүүст шаардлагатай эмчилгээг эрт үе шатанд үзүүлэх.
- Хэвтэж эмчлүүлэх тусламж үзүүлэх эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх.
- Халдварын хяналтын арга хэмжээг чангатгах.

Хилийн хяналтын арга хэмжээ:

- Японд зорчих халдвар авсан хүмүүсийн тоо огцом нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор одоо үйлчилж буй нэвтрэх хязгаарлалт болон аяллын зөвлөмжийг дагаж мөрдөх.

⁶¹ <https://www.mhlw.go.jp/content/10200000/000603611.pdf>

Бусад

- Амны хаалт, халдваргүйжүүлэх бодисын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тасалдуулахгүй явуулах.
- Олон улсын нягт хамтын ажиллагааг үргэлжлүүлж, мэдээлэл солилцох. Японд бий болж буй мэдлэг, мэдээллийг ДЭМБ, холбогдох бусад байгууллага, улс орнуудтай идэвхтэй хуваалцах.
- Өвчтөн болон халдварыг хянах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ажилтнуудын хүний эрхийг хангахад анхаарах.

Шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ

Вирус тархахаас урьдчилан сэргийлэх, бүүруулах талаарх гаргасан зөвлөмж:

- Ерөнхий сайд Ш.Абэ Олон нийтийг хамарсан соёл урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээ хэмжээг 3 сарын 29 хүртэл цуцлах, зохион байгуулах хугацааг нь хойшлуулах, хамрах хүрээг нь хумих зэрэг арга хэмжээ авахыг уриалсан.
- Хүмүүс олноор цугларсан газар, агааржуулалт тааруу газраас зайлсхийх;
- Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагч нар арга хэмжээний хэмжээнээс үл хамааран, нягтрал өндөр байх тохиолдолд, мөн агааржуулалт тааруу газар арга хэмжээ зохион байгуулахаас татгалзах. Арга хэмжээ зохион байгуулах тохиолдолд агааржуулалтад онцгой анхаарахын тус тус зөвлөсөн;

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч буй зарим арга хэмжээ:

- PCR буюу Полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээг эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Ингэснээр Эрүүл мэндийн байгууллага нь хувийн хэвшлийн лабораторид шинжилгээ хийлгэх, цаашид тэдгээрийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.
- ДЭМБ, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг дагах.

Хилийн хяналт, зорчих хөдөлгөөнийг арга хэмжээ:

- Япон Улсын Засгийн газрын коронавирусний асуудлаарх Ажлын хэсгийн 2020.03.05-ны өдрийн хуралдаанаас хил гаалийн хяналтыг бэхжүүлэх чиглэлд БНХАУ, БНСУ-аас Япон Улсад зорчих иргэдийг зөвхөн Нарита болон Кансай олон улсын нисэх онгоцны бүүдлаар хүлээн авах, Японы хилээр нэвтэрсний дараа 14 хоногийн хугацаанд хөл хорионд байлгах, мөн Японд олон нийтийн тээврийн хэрэгсэл ашиглахгүй байхыг уриалсан. Эдгээр арга хэмжээг энэ сарын 9-ний өдрөөс сарын сүүл хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.
 - Мөн 2020.03.07-ны 00:00 цагаас эхлэн БНСУ болон Ираны зарим мужаас Японд зорчих иргэдэд хилийн хориг тогтоохоор шийдвэрлэсэн.
 - 2020.03.09-30-ныг хүртэл гадаадын зарим улстай визгүй зорчих журмыг түр зогсоох.
-

- 2020.03.08-наас өмнө олгосон нэг, олон удаагийн орох визийн хүчинтэй хугацааг түр зогсоох шийдвэрийг тус тус гаргасан.
- 2020.03.09-нөөс хойш БНХАУ, БНСУ иргэдийг хилээр нэвтрүүлэхгүй байх.⁶²

Эдийн засгийн үр нөлөөг бууруулах чиглэлээр авч буй зарим арга хэмжээ

Японы Засгийн газар шинэ коронавирусний халдвараас үүдэлтэй эдийн засгийн үр нөлөөг бууруулахад 4.1 тэрбум ам.доллар баталсан.

Вирусний халдварын тархалттай тэмцэхэд зориулсан (2.6 тэрбум ам.доллар) иенийн яаралтай тусламжийн багцыг баталсан. Түүнчлэн Японы Засгийн газар вирусний халдварын тархалтын улмаас хомсдоход хүрсэн ариутгалын спиртийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд энэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч компаниудад татаас олгохоор болсон.

Засгийн газар энэ асуудлыг зохицуулахын тулд үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг сайжруулахад зориулан хөрөнгө оруулж буй компаниудад татаас олгох бөгөөд томоохон компаниудын уг зардлын гуравны хоёрыг, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн зардлын дөрөвний гурвыг дааж, үйлдвэрлэлийн шугам тутамд 30 сая иен (286 мянга орчим ам.доллар) хүртэлх хэмжээний татаас олгохоор болжээ.⁶³

Японы Засгийн газрын 2020.03.10-ны өдрийн хуралдаанаар:

Вирусний тархалттай тэмцэхэд зориулсан 1 триллион (9.6 тэрбум доллар) иенийн яаралтай тусламжийн хоёр дахь багцыг батлав. Үүнийг бэлэн мөнгөний дутагдалтай жижиг, дунд бизнест 500 тэрбум иенийн хүүгүй зээл олгох, сургууль хаалттай байгаа үед хүүхдээ асарч freelancer буюу чөлөөт ажилтнуудад Засгийн газар өдөрт 4,100 иен олгох зэргээр зарцуулах юм.⁶⁴

2020.03.12-ны байдлаар Засгийн газраас дээрх арга хэмжээг хангалтгүй гэж үзэн гурав дахь багцыг батлахаар төлөвлөж байна.⁶⁵

“Токио-2020” зуны XXXII олимпийн наадам

Токио-2020 зуны XXXII олимпийн наадам нэг жилээр хойшилж байгааг Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ болон Олон улсын олимпийн хороо/ОУОХ/-ны ерөнхийлөгч Томас Бах нар 2020.03.24-ны өдөр баталсан. Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ ОУОХ-ны ерөнхийлөгч Томас Бахт санал тавин зөвшөөрч ийнхүү Токио-2020 олимп 2021 оны зун зохион байгуулагдахаар болж байна.

⁶² https://www.mofa.go.jp/ca/fna/page4e_001051.html

⁶³ <https://www.csis.org/analysis/global-economic-impacts-covid-19>

⁶⁴ <https://www.japantimes.co.jp/news/2020/03/10/national/politics-diplomacy/cabinet-bill-shinzo-abe-state-of-emergency-coronavirus/#.Xmr4RaeB1uU>

⁶⁵ <https://www.japantimes.co.jp/news/2020/03/12/national/japan-third-measures-coronavirus/#.Xmr2BaeB1uV>

Зуны Олимп, Паралимпийн наадмыг зохион байгуулахад Япон улс ойролцоогоор 1.35 их наяд иен буюу 12,6 тэрбум ам.доллар зарцуулах тооцоог өнгөрсөн 2019 оны сүүлээр гаргажээ. Зардлыг Токио хотын төсвөөс 597 тэрбум иен, Японы Олимп зохион байгуулах хорооноос 603 тэрбум иен, Засгийн газраас 150 тэрбум иенийг гаргаж бүрдүүлжээ. Гэхдээ Олимпыг зохион байгуулах зардал ард иргэдийн дунд маргаан дэгдээсэн халуун сэдэв болсон юм. Учир нь энэ нь 2013-2018 оны хоорондох Японы Засгийн газрын зардлаас (1.06 их наяд иен) бараг 10 дахин их төсөв аж. Үүний зэрэгцээ Японы бизнес эрхлэгчдээс Олимпын наадмыг зохион байгуулахад 348 тэрбум иен буюу 3.3 тэрбум ам.долларыг хандивласан байна. Мөн Японы Тоёота, Бриджстон, Панасоник зэрэг томоохон компаниуд Олимпын наадмын спонсорын эрхийн төлөө Олон улсын Олимпын хороотой байгуулсан хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулжээ.

ДНБ-д нөлөөлөх нь

Коронавирусийн халдвар хэдийн Японы эдийн засгийг хямрал руу түлхэж эхэлсэн юм. Эдийн засгийн судалгааны “Fitch” байгууллагын тооцоолсноор Японы эдийн засгийн өсөлт коронавирусийн халдварын нөлөөгөөр энэ онд таамаглаж байснаас 0.2-1.1 хувиар буурах гэнэ. Харин Олимпын наадмыг хойшлуулсан нь Японы ДНБ-д 0.5-0.8 хувиар нөлөөлж магадгүй аж. “SMBC Nikko Securities” байгууллагын эдийн засагчдын тооцоолсноор Японы ДНБ-д жилийн алдагдал нь зургаан тэрбум ам.доллар орчим болох гэнэ. Олимпын наадмыг үзэхээр ирэх жуулчид Японд нийт 240 тэрбум иенийг зарцуулна гэж тооцжээ. Япон нь Олимпын наадмыг үзэх 7.8 сая тасалбараас 4.5 саяыг нь хэдийн борлуулаад байжээ. Олимпын наадмыг хойшлуулсан нь тасалбарт хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна.⁶⁶

⁶⁶ <https://news.mn/r/2278723/>

**ОХУ-ын Засгийн газрын хуралдаанд
Михаил Мишустиний хэлсэн үг⁶⁷**

2020.03.12

Сүүлийн хэдэн өдөр санхүүгийн болон дэлхийн газрын тосны зах зээлд сөрөг үйл явдлууд нөлөөлж байна. Энэ бол коронавирусний тахал бөгөөд Нефть экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК) үйлдвэрлэлийг бууруулах хэлэлцээрээс гарсан шийдвэр юм. Үүнтэй холбогдуулан дараах зүйлийг тэмдэглэхийг хүсч байна.

Нэгдүгээрт. Бид энэ гэрээнээс татгалзах санаачлагч биш байсан. Эсрэгээрээ, бид гэрээг одоо байгаа нөхцөлөөр дор хаяж хоёрдугаар улирал дуустал эсвэл нэг жилээр сунгах санал гаргасан. Коронавирусний тархалттай холбоотой үүссэн нөхцөл байдлыг улам хүндрүүлэхгүйн тулд оруулах хэрэгтэй. Дэлхийн эдийн засаг саарч, олон улсын худалдаа буурсантай холбоотойгоор эрчим хүчний эрэлт буурч байгаа тул бидний байр суурь бүрэн нотлогдож, үндэслэлтэй болов. ОПЕК-ийн орнууд гэрээгээ одоогийн түвшинд шинэчлэхгүй байхаар шийджээ. Мөн ОПЕК-ийн удирдагч болох Саудын Араб нь газрын тосны үнэ урьд өмнө байгаагүй буурч, олборлолтоо дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлж, зах зээлийн уналтад хүргэв.

Хоёрдугаарт. Оросын эдийн засгийн байдал Ерөнхийлөгч, Засгийн газрын хяналтад байна. Бид үүнийг тайван, цочролгүйгээр даван туулах бүх хэрэгсэлтэй. Бидэнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах хангалттай эх үүсвэр бий. ОХУ-ын банктай хамтран нөхцөл байдлыг тогтворжуулах бүх шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч байна. ОХУ-ын банк зах зээл дээр гадаад валютын худалдан авах ажиллагааг 30 хоногоор түр зогсоосон, харин Сангийн яам төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тэдгээрийг зарж байгаагаа зарласан. Эдгээр арга хэмжээнүүд хэдийн тодорхой үр дүнг өгсөн байна.

Одоо зөвхөн Оросын эдийн засаг сөрөг хүчин зүйлсийн нөлөөнд автахгүй байна. Олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар зөвхөн коронавирусний дэгдэлтээс болж дэлхийн бүх эдийн засаг ДНБ-ий хагас хувийг алдах боломжтой.

Энэ бол эдийн засгийн шинэ бодит байдал юм. Дэлхийн хөрөнгийн индекс, газрын тосны үнэ буурсан. Тиймээс гакрын тосны үнэ дөрвөн жилийн өмнө үнэтэй адил болсон.

Гэхдээ тухайн үед сүүлд гарсан үр дагавар нь том байгаагүй. Манай эдийн засаг хүнд нөхцөл байдалд дасан зохицох уян хатан байдал, чадвараа харуулсан. Энэ бол инфляци харьцангуй доогуур нөхцөлд амьдарч байгаа эхний жил биш юм. Одоо бидэнд аюулгүй байдлыг хангах их хэмжээний нөөц байна. ОХУ-ын банкны алтны актив 570 тэрбум ам.доллараас давжээ. Үндэсний баялгийн сангийн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ 10 их наяд гаруй рубльтэй тэнцэж байна. Газрын тосны үнэ тогтвортой буурч байгаа ч эдгээр хөрөнгийн төсвийн алдагдлыг нөхөхөд бидэнд олон жилийн хугацаа шаардагдах болно.

Эдгээр нь нийгмийн бүх үүргээ бүрэн биелүүлэх хангалттай нөхцөл юм. Ерөнхийлөгчийн хэлснээр бид хүмүүсийн эрэлт хэрэгцээнд суурилсан, амьдралын чанар, түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн бодлоготой төрийн бодлогыг хэрэгжүүлэх бүх боломж байна. Үүнд тэтгэмж, төлбөрийн индексжүүлэлтийг хангах зорилгоор төлөвлөсөн зүйлээ оруулсан болно.

⁶⁷ Вступительное слово Михаила Мишустина на заседании Правительства (12 марта 2020).

Эх сурвалж: ОХУ-ын Засгийн газрын цахим хуудас – <http://government.ru/news/39127/#siluanov>.

Гуравдугаарт. Газрын тосны үнэ бага, валютын ханшийн хэлбэлзэл нь манай эдийн засагт эрсдэл учруулах төдийгүй шинэ боломжийг бий болгож байна. Эдгээр нь юуны түрүүнд импортыг орлох хөтөлбөртэй холбоотой байдаг. Энэ нь хэдийнээ үр дүнгээ өгсөн байна. Одоо бид үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт импортын орлуулалтыг гүнзгийрүүлэх нэмэлт арга хэмжээн дээр ажиллаж байна. Бид түүхий эдийн бус, өндөр технологийн бүтээгдэхүүн экспортлох боломжийг өргөжүүлж байна.

Дөрөвдүгээр. Холбооны бүх гүйцэтгэх засаг захиргаа, ОХУ-ын банк үйл ажиллагааг зохицуулах нь чухал юм. Эхний ээлжинд санхүүгийн тодорхой бус байдлаас хүмүүсийг хамгаалахын тулд бид бүх эрсдэлийг багасгаж, ноцтой аюулыг няцаах ёстой. Энэ бол бидний гол зорилго юм.

Тавдугаарт. Гуравдугаар сарын эхээр бид 2021–2023 оны холбооны төсвийг боловсруулахдаа өмнөх эрсдэлийг төдийгүй коронавирүсний халдварын дэгдэлтийн үр дагаврыг харгалзан үзэх шаардлагатай тул хөгжлийн янз бүрийн хувилбаруудад бэлэн байна гэж хэлсэн. Бид Хятад улс болон коронавирүс идэвхтэй тархаж буй бусад орнуудтайгаа хил хязгаараа үнэн бодитоор хаасан муж улсуудын нэг бөгөөд тэдний иргэдийг Орос руу зорчихыг хориглосон. Бид үйл ажиллагааны штаб байгуулж, манай улсад халдвар тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд хэд хэдэн чухал алхам хийв. Бидний хувьд хамгийн гол зүйл бол ард түмнээ хамгаалах явдал юм. Тийм ч учраас би Оросын бүх иргэдийг холбооны, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд, тэр дундаа Москвад авч буй идэвхтэй арга хэмжээг ойлгон хүлээн авахыг хүсч байна. Би бүгдээрээ эрүүл мэнддээ анхаарч, ойр дотны хүмүүсийнхээ эрүүл мэндийг, ялангуяа энэ аюултай өвчинд хамгийн их өртөмтгий байдаг ахмад настнуудынхаа эрүүл мэндэд анхааралтай хандахыг уриалж байна. Бид сайтар шалгасан, үндэслэлтэй бүх арга хэмжээнүүдийг авч байгаа. Түүгээр ч зогсохгүй өчигдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага коронавирүсний халдварын цар тахлын эхлэл гэдгийг албан ёсоор зарлав.

Бид шийдвэр гаргасан: 3 дугаар сарын 13-наас эхлэн Итали, Герман, Франц, Испани руу нислэг түр хугацаагаар хязгаарласан. Үүний зэрэгцээ нислэг үйлдэж Оросын иргэдийг Орос руу буцах боломжийг олгоно. Түүнчлэн холбооны гүйцэтгэх байгууллагууд хамгийн яаралтай байдлаас бусад тохиолдолд бизнес аяллыг зогсоож, ажилчдыг хувийн зорилгоор гадаадад зорчихгүй байхыг зөвлөж байна.

Холбооны болон бүс нутгийн гүйцэтгэх байгууллагуудад бизнес, спорт, цэнгээнт болон бусад олон нийтийн арга хэмжээний тоог хамгийн бага хэмжээнд байлгахыг зөвлөж байна.

Дахин нэг удаа хэлье: бидний авч буй бүх арга хэмжээ коронавирүсаас урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж байна. Энэ бол тэдний гол сэдэл юм. Тиймээс ОХУ-аас гадуур хурц нөхцөл байдал үүссэн ч манай улсад халдвар тархах аюул хамгийн бага байна.